

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний ХШҮ-ний тайлан
Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар
2023 оны жилийн эцэс

[illegible]

2	1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж дундаж наслалтыг уртасгана.	1. Эрүүл ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Тухайн жилдээ	28	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо	Орон нутгийн төсөв 2,0	30	0,7	Эрүүл ажлын байрыг дэмжих чиглэлээр аж ахуй нэгж албан байгууллага, ард иргэдэд дасгал хөдөлгөөн, зөв хооллолт, халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 12500 гаруй иргэнд танхим болон цахим сургалт, зөвлөгөө мэдээллийг өгч ажиллалаа. 60 аж ахуй нэгжид ажлын байранд сургалт мэдээлэл зохион байгуулж ажилласан. Аймгийн засаг даргын захирамжаар дагуу ЗӨВ ХЭВШИЛ-ЭРҮҮЛ АМЬДРАЛ аяныг зохион байгуулан ажиллаж байна. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, Сум өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн 19 байгууллагын ХАБЭА-н ажилтан болон хавсран гүйцэтгэдэг 20 эмч, эмнэлгийн ажилтанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдөх, тэдгээрт нийцүүлэн дотоод дүрэм, журмыг боловсруулан хэрэгжүүлж, аливаа аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах хуулийн мэдлэг ур чадвар дээшлүүлэх зорилгоор МСҮТ-н ХАБЭА-н мэргэшсэн багш нартай хамтран "Сертификат"-тай сургалт зохион байгуулсан. Эрүүл ажлыг байрыг нэмэгдүүлэх зорилгоор 45 байгууллагын төлөөллүүдэд эрүүл мэндийг дэмжих чиглэлээр арга зүйгээр хангах сургалт зохион байгуулж 95 хүнийг хамруулж Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын болзлыг хангасан 2 байгууллагад Гэрчилгээ мөнгөн шагналыг олгож эдгээрийг зардалд 720000 төгрөгийг Засаг даргын нөөц	100%
---	---	--	---------------	----	--	------------------------	----	-----	---	------

3	2. “Хавдрын эсрэг хамтдаа” арга хэмжээг жил бүр зохион байгуулах	Тухайн жилдээ	80	Зорилтот бүлгийн хүн амын хамрагдалтын хувь	Улс орон нутгийн төсөв 5,0	85	о	Хавдрын эсрэг авах арга хэмжээний хүрээнд Гепатитгүй Монголчууд, Элэг бүтэн Монгол, Эрүүл Сүхбаатарчууд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж 2023 оны 10 сарын байдлаар Гепатитгүй Монголчууд төслийн хүрээнд шинээр элэгний хавдрын сэжигтэй 50 тохиолдлыг илрүүлэн дараагийн шатлалын ЭМБ-д илгээн оношлон эрүүлжүүлэх арга хэмжээг авч байна. С вирустэй нийт 652 иргэн ачаалал тоолуулах шинжилгээнд хамрагдсанаас 183 нь С вирусийн ачаалалтай өндөр гарч үүнээс эм уух шаардлагатай бөгөөд ууж хэрэглэсэн хүмүүсийн хувь 54,2 хуьтай байна. 2022 онд Элэг бүтэн монгол хөтөлбөрөөр С вирустэй илэрсэн 1945 иргэнийг хяналтад авч вирусын ачааллыг тоолуулж, эмчилгээнд хамруулан өрх, сумын ЭМТ, АНЭ-ийн нарийн мэргэжлийн эмч нартай хамтран ажиллаж байна. ЭМД-тай, ЭМД-гүй иргэдийг В,С вирус илрүүлэх шинжилгээнд хамруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна.ХСҮТ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө авч хамтран ажиллаж байна.2023 оны 11 сарн 15ны байдлаар хорт хавдрын нас баралт 11 тохиодол буюу 4,2 хувиар буурсан байна. Хүрсэн түвшин : 85	90%
---	--	---------------	----	---	----------------------------	----	---	--	-----

4	3. Эрэгтэйчүүдийн өвчлөл, нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлийг судалж, Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх	Тухайн жилдээ	30	Хэрэгжилтийн хувь	Улс орон нутгийн төсөв 15,0	50	-	Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний хүрээнд эрчүүдийг эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулах, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулж Эрүүл мэндийн цогц үзлэгийг аймгийн бүх сумдад ЭМС-ийн А/30 тоот тушаалын дагуу зохион айгуулж эрсдэлт бүлгийн 2540 иргэнийг хамруулсан.АНЭ-т мэс засал-Урологийн кабинетыг тогтмол ажиллуулж 7 хоногийн мягмар, пүрэв гаригуудад урологийн эмчийн үзлэг хийгдэж байна. 2023 онд АНЭ-ийн амбулаторийн үзлэгт нийт 571 иргэд хамрагдсанаас 159 буюу 27% нь эрэгтэйчүүд хамрагдаж 62 хувьд нь өвчлөл илэрч эрүүлжүүлэх арга хэмжээг авч байна. Мөн жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт хийх, эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний уулзалтад холбогдох эмч, мэргэжилтнийг хамруулан мэдээлэл арга зүйгээр ханган ажилласан.Эмэгтэйчүүдийн дундаж наслалт 2020 онд 78.5, эрэгтэйчүүдийнх 68.04 байсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар эмэгтэйчүүд 79.8, эрэгтэйчүүд 70.4 болж өссөн байна. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү 2020 онд 10.46 байсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар 9.4 болж буурсан хэдий ч анхаарал татсан асуудал хэвээр байна. Хүрсэн түвшин : 50	100%
---	--	---------------	----	-------------------	-----------------------------	----	---	--	------

5	4. Алслагдсан хөдөөгийн хүн амд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг үзүүлэх.	Тухайн жилдээ	9	Хамрагдсан сумдын тоо	Орон нутгийн төсөв 20,0	13	62.5	Асгат, Халзан Дарьганга,Түвшинширээ,Мөнххаан,Онгон,Наран , Уулбаян ,Түмэнцогт, Баруун-Урт зэрэг 10 суманд нарийн мэргэжлийн 9-11 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлж нийт давхардсан тоогоор 15123 иргэн, БЗДХ-ын шинжилгээнд 15-49 насны 3520 иргэнийг тус тус хамруулж илүүрсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн ОНТХ-өө 62,5 сая төгрөгийн оношлуурын зардлыг гарган ЭМД-д хамрагдаагүй иргэдийг эрсдэлд суурилсан эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж 13 суманд холбогдох эмч, мэргэжилтнүүдийг ажиллууллаа. Хүрсэн түвшин : 13	100%
6	5. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт андрологи, урологи, герантологийн тусламж үйлчилгээний кабинет байгуулж эмч мэргэжилтнээр хангах	Тухайн жилдээ	1	Кабинетын тоо	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр 10,0	2	0	АНЭ-т урологи, геронтологи, өсвөр үеийн кабинет үйл ажиллагаа явуулдаг. Андрологи, урологийн кабинетад 159, Өсвөр үеийн кабинетад 50, Геронтлогийн кабинетад 924 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна. Хүрсэн түвшин : 2	70%

7	6. Эрүүл Сүхбаатарчууд төслийг хүрээнд ЭМД-т хамрагдаагүй иргэдийг эрт илрүүлэг үзлэгт хамруулах оношлуур дагалдах хэрэгсэл худалдан авах	Тухайн жилдээ	-	Төрөл	Орон нутгийн төсөв 62,4	5	68,5	Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийн эрт илрүүлэг үзлэгт хамруулах, илэрсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлэх зорилгоор Эрүүл Сүхбаатарчууд төслийг хэрэгжүүлэн орон нутгийн төсвөөс оношлуур дагалдах хэрэгслийг худалдан авах зардалд 62.5 сая төгрөгийг төсөвлөн таван төрлийн оношлуур дагалдах хэрэгсэл худалдан авах тендерийг зарлан оношлуур дагалдах хэрэгслийг 100 хувь татан авч Эрүүл мэндийн даатгалгүй иргэдийг үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг сумдад зохион байгуулсан.Үзлэг шинжилгээнд: Сахар-126 Холестерин-141 ДОХ-0 Тэмбүү-7 Хеликобактер-482 В вирус-14 С вирус-2 Даралт ихсэх өвчин-9 Элэгний хатуурал-1 Элэгний хавдрын сэжигтэй-4 Хөхний хавдрын сэжигтэй-1 Хөхний хоргүй хавдар-2 Уушгины голомт -2 тус тус өвчлөлийг илрүүлэн ажилласан байна. Хүрсэн түвшин : оношлуурын төрөл 5	100%
8	7. БНСУ-ын Южин оптикал эмнэлгийн нүдний эмч нарын үзлэгийг орон нутагт зохион байгуулах	Тухайн жилдээ	-	Хамрагдсан хүний тоо	АЗДҮАХХЗ	1000	700,0 /БНСУ-ын Хөрөнгөөр/, 50,0 /Аймгийн ОНТ-ийн хөрөнгөөр/	БНСУ-ын Южин оптикал хараа зүйн төвтэй хамтран ажиллаж нүдний эмч нарын үзлэгийг орон нутагт зохион байгуулан аймгийн хэмжээнд зорилтот бүлгийн 600 хүүхэд 700 насанд хүрэгчид нийт 1300 иргэнийг хамруулж, хараа шалгаж нүдний шил тааруулан зөвлөгөө өгч, 620 ширхэг харааны шилийг үнэ төлбөргүй олгосон. Мөн үзлэгийн үеэр АНЭ-ийн нүдний эмчийг ажлын байрны дагалдуулах сургалтанд хамруулсан. Хүрсэн түвшин : 1300 хон	100%

9	8. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, сум дундын эмнэлэгт эх, хүүхдийн өвчлөлийг бууруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах төрөлжсөн мэргэжлийн эмч нараас бүрдсэн “Эх хүүхдийн баг”-ийг жил бүр ажиллуулах.	Тухайн жилдээ	4	Ажилласан сумдын тоо	Сумын ОНХС 4,0	8	4,5	Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Эх хүүхдийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах баг Дарьганга суманд Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, өрх сумдын эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилготой үзүүлэх сургууль, сургалт зохион байгуулсан. Тус үйл ажиллагаанд анхан шатны 11 эрүүл мэндийн байгууллагын давхардсан тоогоор 110 эмч эмнэлгийн мэргэжилтнүүд оролцож, өдөрлөг, сургалт сурталчилгаанд 200 эцэг, эх, асран хамгаалагчдыг хамруулсан байна. Хүрсэн түвшин : 110 эрүүл мэндийн ажилтан, 200 эцэг эх	100%
10	9. Уламжлалт анагаах ухааны төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Тухайн жилдээ	60	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	Орон нутгийн төсөв 30,0	85	33,0	2023 онд Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэгийг орон нутгийн төсөв болон хандивын нийт 33 сая төгрөгийн өртөг бүхий 22 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангасан байна. Хүрсэн түвшин : 85	100%
11	10. Хөдөлгөөн засалчийг бэлтгэх	Тухайн жилдээ	0	Бэлтгэгдсэн мэргэжилтний тоо	Улсын төсөв 3,0	1	-	Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийг шаардлагатай хүний нөөцөөр хангах ажлыг зохион байгуулж 2023 онд шинээр бүртгэл мэдээллийн ажилтан, өдрийн эмчилгээний сувилагч мөн уламжлалтын бариа заслын сувилагчийг бэлтгэн ажилд авсан байна. Хүрсэн түвшин : 3	70%

12	11. Эмийн чанар аюулгүй байдалд хяналт тавих, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг орон нутагт чанартай зохион байгуулж зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг нэмэгдүүлэх.	Тухайн жилдээ	85	Зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийн хувь	-	90	1800,0	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан бараа, ажил үйлчилгээг ерөнхий гэрээ байгуулан tender.gov.mn “Цахим дэлгүүр”-ээс худалдан авах талаарх сургалтыг сумын ЭМТ-үүдийн дарга, ахлах сувилагч нарт зохион байгуулсан. 2023 оны 10 дугаар сарын байдлаар АНЭ Ерөнхий гэрээгээр 556,9 сая, шууд гэрээгээр 357,5 сая, тендерээр 688,6 сая, хандив 139,5 сая төгрөг нийт 1 тэр бум 742,7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Үүнээс сумын Эрүүл мэндийн төвүүд ерөнхий гэрээгээр 4,3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Зайлшгүй шаардлагатай мийн хангат 90 хувьтай байна. Хүрсэн түвшин : 90	100%
13	12. Эмч, эмнэлгийн ажилтан, анагаахын салбарын оюутнуудыг дэмжих, урамшуулал олгох журмыг хэрэгжүүлэх	Тухайн жилдээ	5	Урамшуулалд хамрагдсан эмч, мэргэжилтний тоо	Орон нутгийн төсөв 20,0	5	18,5	Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналын журмын дагуу Нэгдсэн эмнэлгийн шилдэг эмч, анхан шатны ЭМТ-ийн шилдэг эмч, шилдэг тусгай мэргэжилтэн, шилдэг ажилтан, шилдэг олныг шалгаруулж тус бүр 3-5 сая төгрөгөөр нийт 18,5 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. Мөн төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн дагуу 2 сувилагчид тус бүр 10,0 сая төгрөгийн урамшуулал олгосон. Хүрсэн түвшин : 100	100%

14	13. Эрүүл мэндийн байгууллагуудыг яаралтай тусламжийн авто машинаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Тухайн жилдээ	0	Энэрэлт-Ачтан, Энхлэн Ачтан ӨЭМТ, Онгон Сумын эмнэлэгийн парк шинэчлэлийн тоо	орон нутгийн төсөв 90,0	3	770,0	Орон нутгийн төсвийн 90,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Онгон сумын ЭМТ, Энэрэлт Ачтан, Энхлэн Ачтан өрхийн эрүүл мэндийн төвүүдэд автомашины парк шинэчлэлт хийгдсэн. Мөн орон нутгийн төсвийн 680,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 суманд туулах чадвар сайтай Ланд-76 маркын автомашин худалдан авах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн орон нутгийн өмчийн газраас тендер шалгаруулалтыг зохион байгуулж Асгат, Түвшинширээ сумдын Эрүүл мэндийн төвүүдийг түргэн тусламжийн автомашинаар хангаад байна. Хүрсэн түвшин : 8 машин	100%
15	14. АНЭ-д хавдрын 85%-тай эрт илрүүлгийн химиолмилнизийн бүрэн автомат анализатор	Тухайн жилдээ	0	Хангагдсан эсэх	орон нутгийн төсөв 100,	1	100,0 сая төг	Орон нутгийн төсвийн 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар АНЭ-ийг иммунологийн бүрэн автомат анализатороор хангасан. Хавсралт : 1 зураг Хүрсэн түвшин : 1	100%

16	1. Иргэдийг спортын олон төрлөөр хичээллэх боломжийг бүрдүүлж, амжилтыг ахиулна.	1. Өсвөрийн шигшээ багийг дэмжих	Тухайн жилдээ						Аймгийн Засаг даргын 2021 оны А/216 дугаар захирамжаар Өсвөрийн шигшээ багийг спортын 8 төрлөөр Засаг даргын ивээл доор байгуулсан. /сагсан бөмбөг, волейбол, шатар, дугуй, жудо бөх, буудлага, үндэсний бөх, хөл бөмбөг/ Спортын тэмцээн уралдаанд амжилт үзүүлсэн өсвөрийн тамирчдад журмын дагуу ганцаарчилсан төрөлд 4,0 сая, багийн төрөлд 8,8 сая төгрөгийн урамшуулал олгосон. Аймагт зохион байгуулагдсан хүүхдийн спортын анхдугаар наадам 11 төрлөөр зохион байгуулагдсан ба 18,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. сагсан бөмбөгийн One dream клубын тамирчдыг УАШТ-д оролцоход нь 4,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Шайбтай хоккейн U 16 өсвөрийн Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулсан ба Улаанбаатар хот, Эрдэнэт, Багануур, Хэнтий аймгуудын 6 багийн 90 гаруй тамирчид оролцсон ба 4,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Сагсан бөмбөгийн өсвөрийн шигшээ багийн дасгалжуулагчийг С ангиллын дасгалжуулагч бэлтгэх сургалтанд хамруулсан ба 3,2 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн. Сүхбаатар аймгийн өсвөр үе залуучуудын аварга шалгаруулах "Хөгжлийн лиг" сагсан бөмбөг, гар бөмбгийн тэмцээн зохион байгуулсан ба 20,0 сая төгрөг зарцуулсан. Хавсралт : 4 зураг Хүрсэн түвшин : 305 үүнээс эр 185, эм 120	61,7	275 /эр-185, эм-90/	Тамирчдын тоо, хүйсээр	Орон нутгийн төсөв 40,0	305 /эр-185, эм 120/	100%
----	--	----------------------------------	---------------	--	--	--	--	--	--	------	---------------------	------------------------	-------------------------	----------------------	------

17	2. Улс, бүсийн чанартай тэмцээн уралдааныг орон нутагтаа зохион байгуулах	Тухайн жилдээ	4	Тэмцээн уралдааны тоо	орон нутгийн төсөв 50,0	6	14	Шайбтай хоккейн U-16 өсвөрийн УАШТ зохион байгуулагдаж, тэмцээнд Улаанбаатар, Эрдэнэт, Багануур, Хэнтий аймгуудын 6 багийн 90 гаруй тамирчид оролцон, шилдэг хаалгачаар Сүхбаатар аймгийн тамирчин шалгарсан ба 4,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Дэлхийн шатрын холбооны мастер Э.Энхнарын нэрэмжит нээлттэй тэмцээнийг зохион байгуулсан ба тэмцээнд 10 аймгийн 23 клубын 300 гаруй шатарчин оролцож 7 ангилалд өрсөлдсөн. Мөн Монголын шатрын холбооны удирдлагын баг бүрэн бүрэлдэхүүнээрээ, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч 2 Монгол Улсын аварга шатарчин 8 их мастер 2 олон улсын мастер 3 ОХУ-ын тамирчин оролцов.Тэмцээний зардалд 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Усанд сэлэлтийн насанд хүрэгчдийн 31 дахь удаагийн улсын аврага шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж, 13 клубын 98 тамирчид оролцсон ба спортын мастер 2, дэд мастер 1 төрөн гарсан ба Монгол Улсын рекордыг 4х50м өврөөр даллах сэлэлтээр /эмэгтэй/, 50м өврөөр даллах сэлэлт /эрэгтэй/, 200м өврөөр даллах сэлэлт /эрэгтэй/, 200м холимог /эрэгтэй/ тус тус эвдэгдсэн. Сүхбаатар аймгийн Асгат сумын уугуул боксын спортын ОУХМастер Мангалсүрэнгийн Отгонбаатар-ын нэрэмжит олон хотын аварга шалгаруулах нээлттэй тэмцээн зохион байгуулагдаж, 10 байгууллагын 108 тамирчинд өрсөлдөв. Өсвөрийн хөл бөмбөгчидийн "Бүсийн цом-2023" тэмцээн	100%
18	3. Засаг даргын нэрэмжит спортын тэмцээн зохион байгуулах	Тухайн жилдээ	-	Тамирчны тоо, хүйсээр	Орон нутгийн төсөв 8,0	350 /эр175, 175/	20	Аймгийн Засаг даргын нэрэмжит "Ахмад-2023" спортын олон төрөлт V наадмыг зохион байгуулсан ба 13 сумын 14 байгууллагын нийт давхардсан тоогоор 474 тамирчид оролцсон. Аймгийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан ба 20,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Хүрсэн тухшин - 732 үнцээс эр 520, эм 212	100%

19	1. Боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж, хүүхдэд ээлтэй зарчим баримталж, насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлнэ.	1. Байгалийн ухааны хичээлийн сургалтын чанарыг сайжруулах, багш нарыг чадваржуулах зорилгоор Шинэ-Монгол сургуультай хамтран ажиллах	Тухайн жилдээ	-	Төсөлд хамрагдах багшийн тоо	Орон нутгийн төсөв 20,0	150	4,0	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “2.3.2.3 Байгалийн ухааны хичээлийн сургалтын чанарыг сайжруулах, багш нарыг чадваржуулах зорилгоор Шинэ-Монгол сургуультай хамтран ажиллах” зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Шинэ Монгол эрдмийн хүрээлэнтэй хамтран ажиллаж байна. 2023 оны 01 дүгээр сарын 23-24 ний өдрүүдэд эхний шатны танхим, дадлагын сургалт үйл ажиллагаа зохион байгуулагдах тул хими-24, физик-20, математик-52, биологийн 25 багш, нийт 120 багшийг хамруулсан. Мөн Шинэ Монгол сургуулийн ерөнхийлөгч Ж.Галбадрах сургуулийн захирал, сургалтын менежерүүдэд зориулсан “Үр дүнтэй сургалт” цуврал лекц зохион байгуулж 60 удирдах ажилтнууд оролцсон. Тус сургалтын арга хэмжээнд АЗД 4,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Хүрсэн түвшин : 180	100%
20		2. Сургууль цэцэрлэгийн багш нарыг компьютероор хангах	Тухайн жилдээ	30	Компьютер ын хангалт	Аймгийн болон сумдын ОНХС 1800,0	100	1800,0	Аймгийн хөрөнгө оруулалтаар 1,300,000,000, сумын хөрөнгө оруулалтаар 600,000,000 төгрөг нийт 1,8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 600 багшийг компьютероор хангах ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж , цахим худалдан авалтаар 2023 оны 6 сард 600 компьютер хүлээж авч , 2023 оны 9 дүгээр сард ЕБС-ийн багш нарт хүлээлгэн өгсөн. Сүхбаатар аймгийн нийт багш ЕБС-д 651, цэцэрлэгт 182 багш ажилладаг. нийт 833 багшаас 600 багшийг компьютержуулж , нийт багш нар 100 хувь шинэ компьютероор хангагдсан. Хавсралт : 1 зураг Хүрсэн түвшин : 100%	100%

21	3. Сургуулийн барилгын чанарыг сайжруулах	Тухайн жилдээ	-	Шинээр засварлах сургуулийн тоо	Төсөл хөтөлбөр, Орон нутгийн төсөв 743,0-ТХ, 656,0-ОНТ	3	1677,0	2023 онд НҮБ-ийн Хүүхдийн сангийн хөрөнгөөр 2-р сургуулийн АЦБ 147,0 сая, Өвсний Үндэс хүний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийн санхүүжилтээр Уулбаян сумын ЕБС-ийн 740,0 сая төгрөгийн их засвар, орон нутгийн хөрөнгөөр Уулбаян сумын ЕБС засварыг 130,0 сая , Түмэнцогт сумын ЕБС-ийн дээврийн их засвар 50,0 сая, Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2-р сургуулийн гадна фасадын их засварыг 510,0 сая, Мөнххаан сумын ЕБС-ийн бага сургуулийн дээврийн их засварыг 100,0 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн . Хүрсэн түвшин : 5	100%
22	4. Сургууль, цэцэрлэг, дотуур байрыг ус цэвэршүүлэгчтэй болгож суралцагчдыг уух цэвэр усаар хангах	Тухайн жилдээ	-	Ус уух нөхцлөөр хангагдсан байгууллага , эзлэх хувиар	Сумдын төсөв 100,0	60	113,7	12 ЕБС, МСҮТ нь 52 ус цэвэршүүлэгч аппарат, 69 цорго, 20 цэцэрлэг 28 аппарат, 161 цоргыг хийж 113,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Хавсралт : 1 зураг Хүрсэн түвшин : 82	100%
23	5. Сургууль, цэцэрлэгт стандартын шаардлага хангасан биеийн тамирын талбай барих	Тухайн жилдээ	-	Шинээр байгуулагдах цэцэрлэгийн гадна талбайн тоо	Орон нутгийн төсөв	2	55,8	Аймгийн 30,0 сая төгрөгийн хөрөнгөөр Мөнххаан сумын цэцэрлэгийн гадна тоглоомын талбай, 20,0 сая төгрөгөөр Уулбаян сумын цэцэрлэгийн гадна спортын талбай байгуулан, Асгат сумын ЕБС гадна биеийн тамирын талбайг 300,0, Баруун-Урт сумын ЕБ 4-р сургууль гадна талбайн хаялга, Асгат сумын цэцэрлэг 5,5 сая төгрөгөөр засварлаж сайжруулсан. Хавсралт : 1 зураг Хүрсэн түвшин : 4	100%

24	1. Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соён гэгээрүүлж, гэр бүлийн боловсролыг дээшлүүлнэ.	1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Тухайн жилдээ	40	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх оролцоог дэмжих дэд хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	ЗДҮАХХЗ 10,0	70	10,7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх оролцоог дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг орон нутагт төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжиж буй Эрүүл монгол хүн үндэсний хөдөлгөөний Цаг гаргая аяны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, амьдралын эрүүл дадал хэвшилтэй болгох замаар гүйлтийн спортыг сурталчлах зорилгоор Итгэл, найдвар, боломж-Баруун-Урт бүх нийтийн гүйлтийг Ахиллис монгол олон улсын байгууллагатай хамтран зүүн бүсийн бүх нийтийн гүйлтийн тэмцээнийг 2023 оны 06-р сард амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд нийт 500 гаруй баг, тамирчид оролцсон ба үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 60 гаруй иргэн, 20 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гүйлтэд оролцсон байна. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын дагуу 2023 онд “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс”-н бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийн оролцоог хангаж, Мөнххаан сумын эрүүл мэндийн төв, Баруун-урт сумын цэвэрлэх байгууламжийн барилгад ажиллаж хүртээмжийн үнэлгээ хийв. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хандлагыг нэмэгдүүлэх, өөрчлөх, хүсэл эрмэлзлэлийг дээшлүүлэх зорилгоор “Тэмүүлэл” НҮТББ-тай хамтран уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, 30 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг	100%
----	--	---	---------------	----	---	-----------------	----	------	--	------

25	2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг дэмжих, сургалт зохион байгуулах	Тухайн жилдээ	0	Сургалт зохион байгуулсан эсэх	ЗДҮАХХЗ 5,0	1	2,0	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг 2023 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас зохион байгуулсан 3 удаагийн танхимын болон цахим сургалтад хамрууллаа. Аймгийн Засаг даргын 2023 оны тоот захирамжаар салбар комиссын бүрэлдэхүүнийг Баруун-Урт суманд ажиллахад 2.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлэв. 2023 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нийт 19 удаа хуралдаж, 166 хүүхдийн асуудлын хэлэлцсэнээс 34 хүүхдийн байнгын асаргааг шинээр тогтоож, 130 хүүхдийн байнгын асаргааг сунган, биеийн байдал сайжирч, эдгэрсэн тул 2 хүүхдийн асаргааг цуцалсан байна. Хүрсэн түвшин : 1	100%
26	3. Амгалант дэнж УТУГ-ын материаллаг баазыг нэмэгдүүлэх	Тухайн жилдээ	-	Ажлын гүйцэтгэл, хувиар	ОНХС 83,2	100	88	Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дэргэдэх “Амгалант дэнж” амралт, сувиллын газрыг ХХҮГазраас 2023 онд зарласан “ахмад настанд хөнгөлттэй нөхцлөөр үйлчилгээ үзүүлэх амралт, сувиллын сонгон шалгаруулалтын шалгуурыг хангах, боломж, нөхцлийг бүрдүүлэх, үйлчилгээний орчин нөхцлийг сайжруулах , ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, үйл ажиллагааг өргөтгөхөд зориулж 88,0 сая төгрөгийн дэмжлэгийн үзүүлсэн ба тус амралт, сувиллын газар нь 2023 нд шинээр 18,5 сая төгрөгийн үнэ бүхий 5 ханатай, бүрэн тавилгатай 2 гэрийг худалдан авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2023 онд тус амралт, сувиллын газар нь 237 ахмад настанд үйлчилгээ үзүүлсэн байна. Хүрсэн түвшин : 100%	90%

27	4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогын хэрэгжилтийг хангах	Тухайн жилдээ	80	Арга хэмжээний хэрэгжилтийн хувиар	ЗДҮАХХЗ 25,0	100	-	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хорооны 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг агентлаг, төсөвт байгууллага, сумдын ЗДТГ, иргэний нийгмийн байгууллага, олон улсын төсөл хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж байна. Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдаж, орон нутагт шинээр 4 сургагч багш бэлтгэгдсэн ба төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн танхимын болон цахим сургалтад 2023 онд шинээр 750 төрийн албан хаагчийг хамруулав. Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих жилийн хүрээнд төсөвт байгууллагууд ажлын байранд хүүхдийн өрөөг байгуулах арга хэмжээ эрчимжсэнээр жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны тоо орон нутагт нэмэгдэж байна. Мөн аймгийн нэгдсэн эмнэлэг ажлын байрандаа хүүхэд харах үйлчилгээг шинээр нэвтрүүллээ. Жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулах арга хэмжээний хүрээнд хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийг сургах арга хэмжээг Баруун-Урт суманд зохион байгуулсанаас гадна Монгол улсын гавъяат багш Х.Баавгайтай хамтран бүх сумдад хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг үзүүллээ. 2023 онд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйчийг ажиллуулж эхлээд байна. Аймгийн ЗДТГ, ЭМГ, холбогдох бусад байгууллагаас эрэгтэчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний	90%
----	---	---------------	----	------------------------------------	--------------	-----	---	---	-----

28	5. Гэр төсөл хэрэгжүүлэх	Тухайн жилдээ	54	Хамрагдах өрхийн тоо	УХЗ 350,0	100	300	БАОНӨГ/20231030 тоот гэрээний дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2023 оны 07-р сарын 25-ны өдрийн А/34 тоот тушаалаар томилогдсон 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 100 гэр хүлээн авах ажлыг төндөрт шалгарсан Дэвжих үүд ХХК-тай хамтран зохион байгуулсаны хүрээнд гэрийг бүрэн хүлээн авч, зорилтот бүлгийн өрхүүдэд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж байна. Хавсралт : 1 зураг Хүрсэн түвшин : 100	100%
29	6. Нутгийн залуучууд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Тухайн жилдээ	30	Хөтөлбөрийн хэрэгжилт	Орон нутгийн төсөв 150,0	60	39.7 /НҮБ-ын хүүхдийг ивээх сангийн хөрөнгөөр/	Нутгийн хөгжилд хамтдаа-Сүхбаатарын оюутнууд арга хэмжээг Улаанбаатар хотод 500 оюутнуудын хамруулан зохион байгуулсан. Тус арга хэмжээнд аймгийн аймгийн Засаг дарга аймгийн хөгжлийн үндсэн илтгэл тавьж залуучуудад хөгжлийн бодлогыг танилцуулж, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр болон орон нутагт дутагдалтай байгаа мэргэжлийн талаарх судалгааг танилцуулж , "Нутгийн хөгжилд хамтдаа", Орон нутгийн хөгжилд оюутнуудын оролцоо " сэдэвт панел хэлэлцүүлгийг хийж, салбар салбарт суралцаж байгаа оюутнуудын төлөөллийг оролцуулан нийт оролцож байгаа оюутнуудын асуултад хариуллаа. Мөн "Аймагт эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа төгсөх ангийн оюутнуудад тэтгэлэг олгох журам" ыг танилцуулсан. Хавсралт : 3 зураг Хүрсэн түвшин : 60	100%

30	1. Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.	1. Иргэдийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрт бэлтгэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Тухайн жилдээ		Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар Орлого багатай иргэдэд чиглэсэн арга хэмжээний хэрэгжилт, хувиар	ХЭДСан ХЭДСан	100 100	43.4	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, ААНБ-тай хамтран “Түншлэл- 2023” хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг амжилттай зохион байгуулав. Уг арга хэмжээнд сургалтад хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн зохион байгуулж, тогооч нарын холбооны тэргүүн Д.Баясгалан болон улсын аврага тогооч П.Сайхантуяа нараар зөвлөгөө өгүүлж, 4 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан байна. Ажил хайгч иргэд болон гэрээр хүүхдээ асарч байгаа эмэгтэйчүүд, МСҮТ-ийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах, ажилд зуучлах “Ажлын гараа – Автобустай аялал ” арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээнд оролцсон 40 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжиж буй үйлчилгээ, арга хэмжээг танилцуулан, 5 иргэнийг ажилд зуучиллаа. Санхүүгийн дэмжлэгт хамрагдаж түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж буй 14 иргэнд 13.2 сая төгрөгийн түрээсийн хөнгөлөлт үзүүлсэн. Мөн Баруун-Урт, Сүхбаатар, Түмэнцогт суманд борлуулалтын цэг нээж 70 иргэний 22.7 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг борлуулж, түрээсийн зардалд 7,5 сая төгрөгийг зарцуулж дэмжлэг үзүүллээ. Уулбаян, Эрдэнэцагаан суманд Ажил олгогч-Бизнес эрхлэгчдийн бүсийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулан санхүүгийн дэмжлэгт	90%
----	--	--	---------------	--	---	------------------	------------	------	--	-----

31	2. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх	Тухайн жилдээ	- 2 30	Цалин хөлсний үзлэгт хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо ХАБЭА-н чиглэлээр урамшуулсан ААНБ-ын тоо Аймгийн 2022-2023 оны гурван талт хэлэлцээрийн хэрэгжилт, хувиар	ЗДҮАХХЗ 15,0	25 3 100	5,0	2023 оны 4-р сард аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талын ажлын хэсэг Түмэнцогт, Сүхбаатар сумдад уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуйн нэгж байгууллагад цалин хөлсний үзлэг, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж, 215 албан хаагчдын хөдөлмөрийн нөхцөл, гэрээтэй танилцаж, холбогдох зөвлөмж, чиглэлийг өгч, ажиллав. Мөн аймгийн Засаг даргын баталсан удирдамж чиглэлийн дагуу хөдөлмөр, нийгмийн зөвшлийн ажлын хэсэг 2023 оны 05-р сард Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр сумдад ажиллаж, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, бусад бодлого, шийдвэрийн хэрэгжилттэй танилцсанаар 2023 онд 31 аж ахуйн нэгж, байгууллагад цалин хөлсний үзлэг хийсэн байна. Эрүүл-аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага улсын уралдаанд Цайртминериал ХХК эрхэмлэгч байгууллагаар шалгарав. /Аймгийн хэмжээнд удирдамжийн дагуу 12 сард шалгаруулна/ Аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2022-2023 оны гурван талт хэлэлцээрийн биелэлт 90%-тай байна. Хүрсэн түвшин : 31 байгууллага, 90%-ийн биелэлт	90%
32	3. Халамжаас хөдөлмөрт арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгийн иргэдийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах	Тухайн жилдээ	200 2	Хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлсэн өрхийн тоо Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг өрхгүй сумын тоо	ХЭДС, бусад	250 3	-	Халамжаас –Хөдөлмөрт арга бодлого, арга хэмжээний хүрээнд 2023 онд аймгийн хэмжээнд нийгмийн халамжийн зорилтот бүлгийн 207 иргэнийг байнгын, 252 иргэнийг түр ажлын байранд зуучилсан байна. 2023 оны 10-р сарын байдлаар аймгийн хэмжээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 169 өрх хамрагдаж буй бөгөөд 2023 онд шинээр 33 өрх халамжаас хөдөлмөрт шилжсэн байна. Аймгийн хэмжээнд 7 сум хүнсний эрхийн бичгийн үйлчилгээгүй байна. Хүрсэн түвшин : 7 сум, 252 иргэн хөдөлмөр эрхлэлтэд шилжсэн	100%

33	1. Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.	1. Соёлын биет болон биет бус өвийг хамгаалах өвлөн уламжлуулах	Тухайн жилдээ						Соёл, урлагийн газар, "Жаахан шарга" театр хамтран Монгол өв соёл, язгуур урлагаа эрхэмлэн дээдэлж, хадгалан хамгаалж, уламжлан хөгжүүлэх зорилгоор цагаан сарын баярыг угтаж "Амар байна уу" эвентийг "DG tower"-ийн Төрийн болон төрийн бус, нэгж байгууллагуудын дунд зохион байгуулагдлаа. Уг эвент нь: Шагай харваа, Шагай шүүрэх, Морь уралдах /шагай/, Түргэн хэллэг, Онъсого таах зэрэг төрлүүдээр дээрх байгууллагуудын 100 орчим албан хаагчид хамрагдсан. Соёлын биет бус өв тээгч, гар урчуудын бүтээлийг сурталчлах, монгол үндэсний дээл хувцасны уламжлалт өв соёлыг таниулах зорилгоор "Монгол гоёл" өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр 1967 оны БНМАУ-ын Ардын зураач Ү.Ядамсүрэнгийн зурсан Ардын хувцас, Малгай, Гоёл чимэглэлийн зургаар үзэсгэлэн дэлгэгдэв. Үзэсгэлэн худалдаанд нийт 142 хүн хамрагдаж 14 хүний 51 төрлийн хувцас гоёл чимэглэл дэлгэгдсэн. Мөн үзэсгэлэнгийн үеэр үзэгч оролцогчдын дунд "Монгол ёс заншил" нэртэй АХА тэмцээнийг зохион байгуулж 38 хүн оролцлоо. Юнеско-ийн хүн төрөлхтний соёлын өвд бүртгэгдсэн "Хавчаахай чавх" харвааг Түмэнцогт суманд зохион явуулсан ба Сүхбаатар аймгийн 12 багийн 80 гаруй баг тамирчид, харваачид оролцсон. Үндэсний их баяр наадам, аймаг байгуулагдсаны 81 жилийн ойн баяр наадмын хөтөлбөрт тусгагдсаны дагуу "Дэгжин монгол" үндэсний хувцсаар гоёх арга	100%
----	--	---	---------------	--	--	--	--	--	--	------

34	2. Орон нутгийн угсаатны зүйн музейн үзмэрийг хүүхэд бүрд үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Тухайн жилдээ	60	Музейн үйлчилгээн д хамрагдсан хүүхдийн тоо, эзлэх хувь	-	70	5,7	Угсаатн ызүйн музей нь Д. Сүхбаатарын амьдрал замналын түүхээр дэглэсэн "Жанжны алдар" үзэсгэлэнг 336, О.Дашбалбарын амьдрал үзэсгэлэнг 3421, зураач Амгалангийн бүтээлүүдээр дэглэсэн "Тасралтгүй оршихуй", үзэсгэлэнг 281, "Миний мөрөөдлийн аймаг" гар зургийн уралдааны бүтээлээр үзэсгэлэн дэглэж 143, "Зураг түүх өгүүлнэ" үзэсгэлэнг 383 үзэгч үзсэн. Мөнгөн урлалын "Нандин өв" үзэсгэлэнг Алтан Овооны тэнгэрийг тайх их тахилгын үеэр мөн Хөрөнгө оруулалт хөгжлийн чуулганы үеэр дэглэн олон нийтэд толилуулсан. "Хүүхэд бүрт музей үзүүлэх зорилтын хүрээнд 8 арга хэмжээ зохион байгуулж, 1024 иргэнийг соёлын боловсрол олгох хөтөлбөрт хамруулан 3500 хүүхдэд музейн тайлбарт үйлчилгээ үзүүлсэн. Сумдын орон нутаг судлах музейнүүдээс Сүхбаатар сум "Жанжны алдар", Наран суманд "Наранбулагийн хүү", Түвшинрширээ сум Х.Монхооройн бүтээлээр "Модоор урлахуй", "Монголын эртний зэр зэвсэг" үзэсгэлэнгүүдийг дэглэж иргэд, хүүхэд залуучуудад үзүүлсэн. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд ЕБС-ын насны 6678 хүүхэд буюу аймгийн ЕБС-ын хүүхдийн 41,8 хувьд СӨБ-ийн насны 2001 буюу аймгийн СӨБ-ийн насны хүүхдийн 31,7 хувь нь музейн үйлчилгээнд хамрагдсан. Хавсралт : 3 зураг Хүрсэн түвшин : 70%	100%
----	---	---------------	----	---	---	----	-----	--	------

35	3. Алтан овооны 110 жилийн ойд зориулан Соёлын өвийн наадам зохион байгуулах	Тухайн жилдээ	1500	Эвент арга хэмжээний үзэгчийн тоо /дунджаар/	Орон нутгийн төсөв 30,0	2500	200,0	Алтан Дарь овоог тайх их тахилгын 110 жилийн ойд зориулан Дарьганга ястны соёл, өв уламжлалыг наадамчин олон түмэнд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор Онгон, Наран, Баяндэлгэр, Дарьганга сумд Дарьгангын Хэлхээ тоонот гэрийг барьж, Орон нутаг судлах музейн үзмэр болон иргэдийн гар дээрх үзмэрүүдээр дэглэж наадмын өдрүүдэд угсаатны зүйн музей нь Дарьгангын мөнгөн урлал, цуглуулагч Дугарсүрэнгийн хүрэл зэвсгийн үеийн олдвор, зурхаач Д.Амараагийн Дарьгангын хүн чулуун хөргүүдийн зургуудаар хамтарсан үзэсгэлэн гаргаж Дарьганга нутаг болон угсаатны онцлог ондоошлыг олон нийтэд сурталчилсан. Мөн Сүхбаатар аймгийн Соёлын биет бус өв тээгч Ш. Чимэдцэээ, уртын болон ардын дуучид, үндэсний урлагийн их театрын уран бүтээлчид оролцож үндэсний онцлог бүхий урлагийн тоглолт, арга хэмжээг олон нийтэд толилуулсан. Хавсралт : 4 зураг Хүрсэн түвшин : 30000 мянган үзэгч	100%
----	--	---------------	------	--	-------------------------	------	-------	--	------

36	4. Угийн бичиг хөтлөх арга хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Тухайн жилдээ	41,5	Угийн бичиг хөтлөлтийн хувь	-	42,3	-	Угийн бичиг хөтлөлтийн өрхийн хувийг нэмэх зорилт дэвшүүлэн салбарын байгууллагын дарга нартай байгуулсан гэрээнд тусган, угийн бичиг соёлын боловсролын хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна. Баруун Урт сумын 25 байгууллагын эцэг эхийн зөвлөлд угийн бичгийн сургалтыг Соёл урлагийн газраас, сумын соёлын төвүүд, насан туршийн боловсролын төвтэй хамтран иргэдэд угийн бичгийн сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Сүхбаатар аймгийн ахмадын холбоотой хамтран "Ахмадаас суралцъя" угийн бичгийн үзэсгэлэнг зохион байгуулж 10 сумаас шалгарсан 31 бүтээл оролцож хамгийн бүтээлч угийн бичиг 3 байр, хамгийн олон үеэ хөтөлсөн бүтээлээр 3 байр эзлүүлж ахмад үе мэдлэг туршлагаа хойч үедээ өвлүүлэн, угийн бичиг хөтлөх ач тусыг олон нийтэд таниулах, алдаршуулах, залуу үе ахмад настны хамтын оролцоог сайжруулах, харилцан мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Хавсралт : 3 зураг Хүрсэн түвшин : 100%	100%
----	---	---------------	------	-----------------------------	---	------	---	---	------

[illegible]

39	1. Аймгийн төсвийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсвийн тогтолцоог бүрдүүлнэ.	1. Төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай үзүүлэх "пос" төхөөрөмжийг иргэдтэй харилцагч Татварын улсын байцаагчид олгох.	Тухайн жилдээ	2	Пос төхөөрөмжийн тоо	ЗДҮАХХЗ 3,0	5	-	Төрийн албаны санхүүгийн нэгдсэн систем болон санхүүгийн imrald системүүдийг тус тус үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглаж байна. Төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай үзүүлэх үүднээс сумдын Засаг даргын тамгын газруудтай хамтран ажиллаж Асгат, Халзан, Баруун-Урт, Баяндэлгэр, Уулбаян, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдын татварын улсын байцаагч нарт цахимаар татварын орлого хураах пос төхөөрөмж худалдан авч өгөөд байна. 2024 онд бусад сумдын татварын улсын байцаагч нарт пос төхөөрөмжийг олгох талаар сумдын ЗДТГ-тай харилцан тохиролцсон болно. Харин аймаг орон нутгийн төсвөөс татварын улсын байцаагч нарыг пос төхөөрөмжөөр хангах талаар ямар нэгэн төсөв болон худалдан авалт хийгдээгүй болно. Хүрсэн түвшин : 6	100%
----	--	--	---------------	---	----------------------	-------------	---	---	--	------

40	2. Төвлөрсөн халаалтанд холбогдсон төсөвт байгууллагуудад дулааны тоолуур суурилуулах асуудлыг үе шаттай шийдвэрлэж, төсвийг хэмнэлттэй зарцуулах нөхцлийг бүрдүүлнэ.	Тухайн жилдээ	0	Тоолууржуулсан байгууллагын тоо	Байгууллагуудын урсгал төсөв	10	ААНБ-ын зардлаар	Баруун-Урт сумын хэмжээнд орон нутгийн төсөвтэй харьцдаг, халаалтын төвлөрсөн системд холбогдсон, өөрийн эзэмшлийн тусдаа барилга байгууламж бүхий нийт 21-н төсвийн байгууллага байдаг бөгөөд 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 14-н байгууллагад дулааны тоолуур суурилуулж, халаалтын төлбөр тооцоо нь холбогдох журмын дагуу хийгдэж байна. Үлдсэн байгууллагуудыг тоолууржуулах ажлыг 2023-2024 оны батлагдсан төсвийн халаалтын зардалд зохицуулалт хийх замаар шийдвэрлэнэ. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар дулааны эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглээг бий болгох зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай 144 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн төвийн төвлөрсөн халаалтад холбогдсон 47 байгууллагаас 17 байгууллагад дулааны тоолуур суурилуулагдсан ба төрийн бус 9 ААНБ одоогоор суурилуулаад байна. Хүрсэн түвшин : 17	70%
41	3. Газар, үл хөдлөх эд хөрөнгө, авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн бүртгэлийг бодитоор тодорхойлох.	Тухайн жилдээ	0	Хөрөнгийн бүртгэл бодитой эсэх	ЗДҮАХХЗ 5,0	1	-	Сүхбаатар аймгийн ГХБХБГазарт 2023 онд жилийн эцсийн байдлаар барилга байгууламж-115825104, газар –28152000, тээврийн хэрэгсэл -148536755.50 төгрөгний үл хөдлөх бүртгэлтэй байна. Хүрсэн түвшин : 1	100%

42	4. Аймгийн хэмжээний даатгалын үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдтэй хамтран иргэдэд даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах, сурталчлах арга хэмжээ зохион байгуулах.	Тухайн жилдээ	30000	Мэдээлэл хүргэсэн иргэдийн тоо	ЗДҮАХХЗ 3,0	35000	-	Аймгийн хэмжээнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 119 иргэн байдаг бөгөөд аймгийн төвд болон 12 суманд гэнэтийн осол, эмчилгээний даатгал, хөрөнгийн даатгал, автотээврийн хэрэгслийн даатгал, мал амьтдын даатгал, автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал, урт хугацааны даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тус онд гэнэтийн ослын даатгалд 1680 иргэнийг 50,6 сая төгрөгөөр, хөрөнгийн даатгалд 5 иргэнийг 5,1 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн даатгалд 310 иргэнийг 188,9 сая төгрөгөөр, жолоочийн хариуцлагын даатгалд 6862 иргэнийг 325,7 сая төгрөгөөр, мал амьтдын даатгалд 131,9 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалд 1355 иргэнийг 64,6 сая төгрөгөөр, унаач хүүхдийн даатгал 127,7 сая төгрөг, зээлийн эрсдлийн даатгалд 1737 иргэнийг 214,5 сая төгрөгөөр тус тус хамруулсан бөгөөд зуучлалын үйл ажиллагааны чиглэлээр 25,4 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна. Даатгалын нөхөн төлбөрт гэнэтийн ослын даатгалаар 47 иргэнд 17,2 сая, хөрөнгийн даатгалаар 6 иргэнд 4,5 сая, автотээврийн хэрэгслийн даатгалаар 24 иргэнд 22,1 сая, жолоочийн хариуцлагын даатгалаар 140 иргэнд 93,0 сая, эрүүл мэндийн даатгалаар 172 иргэнд 6,6 сая, МИД даатгалаар 26 иргэнд 16,9 сая төгрөг, зээлийн эрсдлийн даатгалаар 3 иргэнд 10,7 сая төгрөгийг тус тус	90%
----	---	---------------	-------	--------------------------------	-------------	-------	---	--	-----

43	5. Жилийн эцсийн өрх, хүн, мал тооллогыг зохион байгуулах	Тухайн жилдээ	0	Зохион байгуулсан ажлын гүйцэтгэл	ЗДҮАХХЗ 15,0	100	-	2023 оны жилийн эцсийн мал тооллогын хяналтын зардлын тооцоог төсөвлөн, тооллого явуулах тухай болон түүнд зарцуулагдах хөрөнгөтэй холбоотой аймгийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулж, 11-р сарын 16-ны өдөр мал тооллогын зардлын тухай аймгийн Засаг даргын А/642 дугаар захирамж, тухайн өдөр тооллого явуулах тухай аймгийн Засаг даргын А/641 дүгээр захирамжуудыг тус тус гаргасан. Мал тооллогын зардалд аймгийн Засаг даргын А/642 дугаар захирамжаар мал тооллогын сургалт, аймгийн комиссын гишүүдийн хяналтын зардал 14.8 сая төгрөгийг батлан гаргасан. Сумдад мал тооллогын сургалт, зөвлөмж өгөх ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 21-нээс 12 дугаар сарын 01-ний хооронд 13 суманд очиж хийхээр төлөвлөн ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн өрх, хүн, мал тооллогыг ажил 2023 оны 12 дугаар сарын 07-ноос 17-ны хооронд явагдаж, 12 дугаар сарын 30-ны өдөр үр дүнг урьдчилсан байдлаар нийтэд зарлана. Хавсралт : 1 файл Хүрсэн түвшин : 100	100%
----	---	---------------	---	-----------------------------------	--------------	-----	---	---	------

44	6. Статистикийн анхан шатны мэдээ, тайлангийн чанарт анхаарч сумд, ААНБ-д улсын байцаагч нарын хяналт, шалгалтыг сайжруулах	Тухайн жилдээ	0	Хяналт, шалгалт хийсэн сум, байгууллагын тоо	ЗДҮАХХЗ 6,5	13 сумын 120 байгууллага	-	2023 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар хэлтсийн дарга бөгөөд улсын байцаагч Т.Эрдэнэбат нь мэргэжилтнүүдийн цуглуулсан салбарын анхан шатны мэдээнүүдэд 2 удаа хяналт хийж, гарсан алдаа зөрчлийг дор бүр нь арилгуулж, анхаарч ажиллах санамжийг өгсөн. Хэлтсийн ажилтнууд хариуцсан салбарын хүрээнд жилийн эцсийн ААНБ-1,2 мэдээнд хамрагдасан 225 ААН-ийн мэдээ, тайлан шалгаж, аймгийн Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн, Татварын хэлтсийн аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан хариуцсан ахлах мэргэжилтэн нартай хамтран жилийн эцсийн санхүүгийн балансыг буруу гаргасан 25 аж ахуйн нэгжийн тайлангын алдааг засуулан хамтран ажилласан. Мөн хагас жилийн малын түүвэр судалгааны хүрээнд Эрдэнэцагаан, Дарьганга бусад сумдад хяналтын ажлыг зохион байгуулж анхан шатны мэдээ, тайлангийн гаргалтыг сайжруулах талаар заавар зөвлөгөөг агч ажилласан. Хүрсэн түвшин : 13 сум 120 байгууллага	90%
----	---	---------------	---	--	-------------	--------------------------	---	---	-----

45	1. Ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар орон нутагт оруулах хувь нэмэр, үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	1. Уул уулрхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн экспортын авто замыг сайжруулах, засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	Тухайн жилдээ	6	Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн авто зам барих ажлыг үе шаттай хэрэгжүүлж байгаа аж ахуй нэгжийн тоо	-	8	-	Сүхбаатар аймгийн хэмжээнд уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа 12 ААН-гүүдэд ЗТХЯамны СХГ-ын ерөнхий байцаагчийн 04/12, 04/20, 04/24 дугаартай төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийлээ. Үүнд: 1.ТХШ-аар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын хүрээнд: -Сүхбаатар суманд байрлах Дорнын чулуулаг ХХК нь "Велдедлайне Монголиа" ХХК-тай гэрээ байгуулан уурхайгаас Бичигтийн боомт хүртэлх 200км авто замын 3 хэсэгт 82 км-т, Түмэнцогт суманд байрлах Монгол Жүюань Ли ХХК нь уурхайгаас Түмэнцогт-Хэнтий чиглэлийн хатуу хучилттай авто зам хүртэлх 1 км хайрган хучилттай авто зам, замын байгууламжид засвар арчлалтын ажил тус тус хийгдэж байна. -Цайрт минерил ХХК аймгийн төвийн урд талын болон Баруун-Урт -Уурхай хүртэлх тээврийн авто замын эвдрэлтэй хэсгүүдийг засварлаж сайжруулсан. -Эм Эл цахиурт овоо ХХК нь Талын зам ТӨХК-тай гэрээ байгуулан Баруун-Урт -Асгат чиглэлийн авто зам хүртэлх ердийн шороон замын эвдрэлтэй хэсгүүдэд засвар арчлалт хийж гүйцэтгэсэн. 2.УСХШ-ын хүрээнд: -Эрдэнийн олз, Бадмаараг хаш, Андын илч ХХК-иудын хайрган хучилттай 42 км авто замд УСХШалгалтыг хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 21 заалттай 3 хугацаатай албан шаардлага хүргүүлж ажилласан. Хугацаа болоогүй. -Алаг тогоо ХХК нь шалгалтын	90%
46		2. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай нутгийн захиргааны байгууллага хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах	Тухайн жилдээ	12	Гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо	-	16	-	Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/274 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай хэлцэл зохион байгуулж гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж хяналт тавьж ажиллаж байна. Хүрсэн түвшин : 15 ААН-тэй гэрээ байгуулсан	100%

47	1. Малын ашиг шимийг нэмэгдүүлэн, малын эрүүл мэндийг хамгаалснаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх.	1. Өвлийн хүлэмжийн аж ахуйг шинээр байгуулах	Тухайн жилдээ	0	ААНэгжийн тоо	Хувийн хөрөнгө оруулалт	1	520,0	Өвлийн хүлэмж барих ажлыг хувийн хэвшлээс санаачилж 2024 оны УТ-оор өвлийн хүлэмж барих ажлын санхүүжилт шийдэгдсэн. Хувийн хэвшлээс зураг төслийг боловсруулсан. Хүрсэн түвшин : 1	50%
48		2. Нийлэг хальсан хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэх	Тухайн жилдээ	3,6	Нийлэг хальсан хүлэмжийн тариалалт га-аар	Төсөл хөтөлбөр, хувийн хөрөнгө оруулалт	4	80	Шинэ хөдөө" төслийн 80.0 сая төгрөгийн хөрөнгөөр "Алтынсапа"ХХК 60 м2 бүхий 10 ширхэг хүлэмж, 32 м2 бүхий 20 ширхэг хүлэмж нийлүүлж, 27 иргэнд хүлэмжний үнийг 4 жилийн хугацаанд буцаан төлөх нөхцөлөөр олгосон. Хүрсэн түвшин : 12.4 га	90%
49		3. Зоорины аж ахуйн ашиглалтыг сайжруулж, иргэдэд чанартай хүнсний ногоо нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх	Тухайн жилдээ	-	Зоорь ашиглагчийн тоо	-	2	80,0	"Шинэ хөдөө" төслийн 80.0 сая төгрөгийн хөрөнгөөр "Алтынсапа"ХХК 60 м2 бүхий 10 ширхэг хүлэмж, 32 м2 бүхий 20 ширхэг хүлэмж нийлүүлж, 27 иргэнд хүлэмжний үнийг 4 жилийн хугацаанд буцаан төлөх нөхцөлөөр олгосон.Жил бүр 1000 гаран тн төмс, хүнсний хураан авч байгаа ашиглалтанд байгаа зоорь агуулахын багтаамж 420 тн байна. Шинээр нэмэж төмс, хүнсний ногоо хадгалах зоорь агуулах баригдаагүй. Ашиглалт хэвийн 5 зооринд 280 тн төмс, хүнсний ногоо хадгалж байна. Мөн орон нутгийн хэмжээнд 91 га талбайд төмс, 87,5 га талбайд хүнсний ногоо тариалж төмс 606 тн, хүнсний ногоо 575 тн ургац хураан авсан. Энэ нь хүн амын хэрэгцээт төмсний хангамжийн36.7 хувь, хүнсний ногооны хангамжийн 11.5 хувьд хүрсэн. Хүрсэн түвшин : 5	70%

50	4. Цэвэр үүлдрийн болон эрлийз, цус сайжирсан малын тоог нэмэгдүүлэн гадаадын өндөр ашиг шимт эцэг малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх	Тухайн жилдээ	400	Зохиомол хээлтүүлэгт хамрагдсан малын тоо	5,0	450	-	Аймгийн хэмжээнд Дорнод монголын улаан үүлдрийн үхэр, Үзэмчин үүлдрийн хонь, Баяндэлгэрийн улаан үүлдрийн ямааг бие даасан үүлдрээр батлуулан өсгөн үржүүлж байна. Цэвэр үүлдрийн болон эрлийз, цус сайжирсан малын тоо өнгөрсөн онтой харьцуулахад 90870 толгой буюу 4.5 хувиар өссөн. Энэ нь нийт мал сүргийн 49.7 хувийг эзэлж байна. 2022 оны жилийн эцэст Дорнод монголын улаан үүлдрийн цэвэр болон эрлийз, сайжирсан үхэр нийт үхрийн 14.6 хувь болох 49776 толгой, Үзэмчин үүлдрийн цэвэр болон эрлийз, сайжирсан хонь нийт хонины 52.0 хувь болох 1252999 толгой, Баяндэлгэрийн улаан үүлдрийн цэвэр болон эрлийз, сайжирсан ямаа нийт ямааны 64.9 хувь болох 962585 толгой тус тус тоологдоод байна. Өндөр ашиг шимт Ангус, Герефорд, Симменталь, Алатау, Хар тарлан үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үрээр Баруун-Урт, Түмэнцогт, Сүхбаатар сумдын 35 иргэн, аж ахуй нэгжийн 170 толгой үнээнд, махны чиглэлийн суффолк хуцны халуун үрээр Мөнххаан суманд 160 хонинд зохиомол хээлтүүлэг хийсэн. Хүрсэн түвшин : 330 толгой малд зохиомол хээлтүүлэг хийсэн.	90%
----	---	---------------	-----	---	-----	-----	---	---	-----

51	5. Халдварт зоонози өвчний гаралтыг багасган уг өвчнөөр тайван, халдваргүй бүсээр баталгаажуулах	Тухайн жилдээ	-	Халдварт зоонози өвчин гаралтын хувь	-	-	-	2023 онд Гоц халдварт, зооноз өвчнөөс эрүүл тайван статус батламж авах ажлын хүрээнд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/40 дугаар тушаалаар батлагдсан “Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээллэх журам”-ыг үндэслэн Түмэнцогт сумын 3 малчны бүлгийн 12 малчин өрхийн мал сүргийг гоц халдварт шүлхий, бог малын мялзан, цэцэг, халдварт зооноз бруцеллёз, сүрьеэ өвчингүй, тайван байдлыг 2021 онд баталгаажуулж батламж өгч ажилласан ба дээрхи малчин өрхүүдийн мал сүргийн эрүүл, тайванг баталгаажуулах тандалт шинжилгээг аймгийн МЭЛ, УМЭАЦТЛ-д хийж ажилласан. Хавсралт : 1 зураг Хүрсэн түвшин : Түмэнцогт сумын 3 малчны бүлгийн 12 малчин өрхийн мал сүргийн эрүүл, тайванг баталгаажуулах тандалт шинжилгээг УМЭАЦТЛ-д хийж ажилласан.	90%
----	--	---------------	---	--------------------------------------	---	---	---	--	-----

52	6. Эрсдэлт бүс нутгийн өвчлөмтгий мал сүргийг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд бүрэн хамруулах	Тухайн жилдээ	- - 83,3 /3-р улирал байдлар /	Шинээр Вакцин хадгалах зориулалтын хөргүүр контайнерт ай болсон сумын тоо Шинээр Вакцинд хамруулахад шаардагдах бод малын хашаатай болсон багийн тоо Вакцинжуулалтын хамралтын хувь /жилийн дундаж/	Улсын төсөв 1040,0 Сумын төсөв 335,0	13 67 100	-	2023 онд 1.Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх 1, 2-р ээлжийн дархлаажуулалтад нийт 5055 өрхийн 128153 хонь, 122237 хурга нийт 250390 той бог малыг хамруулж гүйцэтгэл 98,7 % 2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтанд 5880 өрхийн 411512 толгой мал хамрагдаж 99.0%-ийн гүйцэтгэлтэй хийгдсэн ба намрын дархлаажуулалтын арга хэмжээнд 3441 өрхийн 252300 үхэр, 46697 тугал нийт 298997 толгой мал хамрагдаж өнөөдрийн байдлаар 74.1%-ын гүйцэтгэлтэй хийгдэж байна. 3. Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын арга хэмжээнд Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдын 74000 мянган үхрийг хамруулахаар төлөвлөснөөс 72534-н үхэр 98%-ийн гүйцэтгэлтэй хамрагдсан. 4.Онгон, Баяндэлгэр сумдад гоц халдварт Бог малын мялзан өвчин оношлогдсонтой холбогдуулан эрсдэл бүхий 9 сумын 588.3 толгой өвчлөмгийг малыг урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулахаас 860 өрхийн 406471 толгой малыг хамруулан одоогоор 72,2%-тай хийгдэж байна. 2022 онд 4 төрлийн гоц халдварт өвчин оношлогдож тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байсан бол 2023 онд 2 төрлийн гоц халдварт өвчин оношлогдож, халдварлалт буурсан байна. Хавсралт : 4 зураг	100%
----	--	---------------	--------------------------------------	---	--------------------------------------	-----------------	---	---	------

53	7. Бэлчээрийн эрүүл ахуйг сайжруулах хүрээнд ариутгал, халдваргүйтгэлийг сайжруулах	Тухайн жилдээ	- 2,1 /3-р улирал байдлаар/	Шинээр тусгай зориулалтын тоноглогдсон халдваргүйтгэлийн автомашинтай болох Ариутгал халдваргүйтгэл хийгдсэн талбайн хэмжээ /жилийн дундаж сая м2/	Улсын төсөв 60,0	тийм 3,6	420,0	Зүй бусын хорогдлоор аймгийн хэмжээнд 772138 толгой мал амьтан хорогдсоноос 13 суманд 34 ажлын хэсэг гарч 44 устгалын цэгт тэмээ-87, адуу- 22759, үхэр-29867, хонь-332141, ямаа-299657, амьтан- 983 нийт 685494 толгой буюу 88,7 %-тай устгал хийж 2162.4м2-т талбайд халдваргүйтгэл хийгдээд байна.Малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийн бодисын нөөцийг МЭГ-ын эмийн нөөцөд бүрдүүлж 13 сумдад 36.893.752 төгрөгийн ХХ-ын хувцас 294ш, хлорын шохой 2550 кг, ханкон 257 кг, суперкиллер 75 кг, спирт 11,4 л тус тус хувиарлан ариутгал халдваргүйтгэлд ашигласан. Хавсралт : 1 зураг Хүрсэн түвшин : Нийт 2,1 сая мкв талбайд халдваргүйтгэл хийгдсэн. Ариутгал халваргүйтгэлийн дук машинаар 7 сум хангагдаад байна	70%
54	8. Мал эмнэлэгийн лабораторийг биохимийн шинжилгээ хийх тоног төхөөрөмжөөр хангах	Тухайн жилдээ	-	Хангагдсан эсэх	Орон нутгийн төсөв 68,7	1	68,1	Лабораторийн техник тоног төхөөрөмжийг сайжруулах зорилгоор орон нутгийн 68.1 сая төгрөгийн хөрөнгө оруултаар Мал эмнэлгийн лабораторийн биохимийн шинжилгээний тоног төхөөрөмж 10 ширхэгийг нийлүүлээд байна. Хавсралт : 3 зураг Хүрсэн түвшин : Тоног төхөөрөмжөөр хангагдсан.	100%

55	9. Бүтээгдэхүүн, үйлчилгээний оюуны өмчийн патент, чанар стандартыг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагын зөвлөн туслах үйлчилгээг бизнес эрхлэгчдэд хүргэх ажлыг зохион байгуулах	Тухайн жилдээ	3	Тохирлын баталгаажуулалт хийгдсэн бүтээгдэхүүн ний тоо	Орон нутгийн төсөв 5,0	4	2.6	2023 оны 11 дүгээр сарын 9-өөс 10-ны өдөр бүх сумдын хүнсний үйлдвэр эрхлэгчийн төлөөлөгчийг хамруулсан 100 хүний сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Сургалтыг Улсын Стандарт хэмжил зүйн газраас 2 сургагч багшийг урьж бүтэн хоёр өдрийн сургалт зохион байгуулна. Хүрсэн түвшин : -	70%
56	10. Сум хөгжүүлэх сан, ЖДҮ сан, Төсөл хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл олголтыг орон нутгийн үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан олгож, ажлын байрыг нэмэгдүүлэх	Тухайн жилдээ	18 75	ААН-ийн тоо Ажлын байрны тоо	Улс төсөв 500,0	26 105	2100	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийн сангаас 2023 онд Сүхбаатар аймагт нийт 1,0 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд тус санхүүжилтэд аймгийн хэмжээнд 22 аж ахуй нэгжийн 2,2 тэрбум төгрөгийн төсөл хүлээн авсан. Эцсийн шалгаруулалтад эрчимжсэн аж ахуй, мах, арьс шир боловсруулах, мал эмнэлэг, гахайн аж ахуй, оёдлын чиглэлийн 8 аж ахуй нэгж нийт 995,8 сая төгрөгийн санхүүжилт авч, 22 ажлын байр хадгалж, 26 ажлын байр шинээр бий болгосон байна. Мөн энэ онд орон нутгийн төсвөөс 300,0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг баталж шувуун аж ахуй, оёдол, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлийн 3 аж ахуй нэгжид нийт 192,7 сая төгрөгийн санхүүжилт олгосоноор 10 ажлын байр хадгалж, шинээр 6 хүнийг ажлын байраар хангасан байна. Хоршоо хөгжүүлэх сангаас 7 сумын 43 аж аж ахуй нэгж, хоршоо, иргэнд нийт 937,0 сая төгрөгийн санхүүжилтыг 2023 олгосон байна. Хүрсэн түвшин : Хөнгөлөлттэй зээлийн хүрээнд нийт 130 ажлын байр хадгалж, 120 шинэ ажлын байр бий болгосон.	100%

11. Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Тухайн жилдээ	30	Төлөвлөгөө ний хэрэгжилти йн хувь	5,0	50	5.5	2023 оны "Намрын ногоон өдрүүд-Сүхбаатарт үйлдвэрлэв-2023" арга хэмжээний хүрээнд стандартын шаардлага хангасан, бренд бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор Шинэ санаачилга, шинэ бүтээгдэхүүн, Импорт орлох бүтээгдэхүүн, Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн гэсэн 3 номинацыг энэ онд шинээр нэр дэвшүүлэн сонгон шалгаруулж, мэргэжлийн байгууллагуудын зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, шилдэг бүтээгдэхүүн өргөмжлөл, тус бүр 200,0 мянган төгрөгөөр шагнаж урамшуулж ажилласан. Орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар стандартыг сайжруулах зорилгоор ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны цогц сургалтыг 2023 оны 10 сарын 09-ний өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Хүрсэн түвшин : Чанар, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг урамшуулж, хөгжүүлсэн	70%
--	------------------	----	--	-----	----	-----	--	-----

58	12. Сүхбаатар хөгжил арга хэмжээний хүрээнд "Эрүүл хүнс", "Алтан намар", "Сүхбаатарт үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулах	Тухайн жилдээ	110	Оролцсон ААН, иргэд /тоо/	Орон нутгийн төсөв 9,2	110	5.5	алчид, үйлдвэрлэл, үйлчилгээ, тариалан эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор жил бүр уламжлан болгон зохион байгуулагддаг "Намрын ногоон өдрүүд- Сүхбаатарт үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдаа 2023 оны 10 сарын 02,03-ны өдрүүдэд Баруун-Урт хотод амжилттай зохион байгуулагдаж, шилдэг бүтээгдэхүүн, үйлдвэр эрхлэгчиддээ дараах номициудад шалгарууллаа. - Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн - Шилдэг сав баглаа боодол - Шилдэг хоол үйлдвэрлэл - Шилдэг хоршоо - Шилдэг тариаланч - Шинэ санаачлага, шинэ бүтээгдэхүүн - Импортыг орлох бүтээгдэхүүн - Шилдэг хүнс үйлдвэрлэгч - Шилдэг хөнгөн үйлдвэрлэл эрхлэгч Шилдэг үйлдвэр эрхлэгчдийг тус бүр цом, өргөмжлөл, 200,000 төгрөгөөр шагнаж урамшуулсан бол сум орон нутгаа амжилттай зохион байгуулж оролцсон Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын хамт олныг шилжин явах цом, 700,000 төгрөг, Дэд байр эзэлсэн Түвшинширээ сумын Засаг даргын Тамгын газрын хамт олныг өргөмжлөл, 500,000 төгрөгөөр шагнаж урамшууллаа. Энэхүү арга хэмжээнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас нийт 6,0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. Үзэсгэлэн худалдаанд 12 сумын 100 үйлдвэр эрхлэгчид	100%
59	13. Бизнес эрхлэгчдэд инкубаторын үйлчилгээг хөгжүүлэх	Тухайн жилдээ	6	Хамрагдаж буй ААН тоо	-	8	50	Орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх инкубаторын үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий "Сүхбаатар хөгжил" ОНӨААТҮГазрын үйлдвэрлэлийн 1-р бүсийн бизнес инкубатор төвд 6 иргэн, аж ахуй нэгж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тогтмол явуулж байна. Хүрсэн түвшин : 6 үйлдвэр ААН тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна.	70%

60	14. Үйлдвэрлэлийн бүс байгуулах зураг төсөв боловсруулах /Баруун урт сум/	Тухайн жилдээ	-	Талбайн хэмжээ, га	Орон нутгийн төсөв 200,0	200 га	200,0	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх 2-р бүсийг Баруун-Урт сумын 8-р багийн нутаг дэвсгэрт төлөвлөж үйлдвэрлэлийн бүс байгуулах зураг төсвийн ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг 2023 онд сонгон шалгаруулж "Ланд овнер" ХХК орон нутгийн 200,0 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэж, хүлээлгэн өгөөд байна. Хүрсэн түвшин : Зургийн ажил бүрэн хэрэгжсэн.	100%
61	15. Загвар хоршоо байгуулах	Тухайн жилдээ	1	Кластерийн тоо	10,0	1	50,0	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх орон нутгийн тэргүүлэх чиглэлийн бодлогын хүрээнд 2023 онд орон нутгийн төсвөөс урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт 300,0 сая төгрөг баталсан. Тус санхүүжилтээр Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж буй оёдлын чиглэлийн "Бумт алтан шаглаа" хоршоонд 50,0 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Тус хоршоог цаашид загвар хоршоо болгон бойжуулах ажил арга хэмжээг үе шаттай зохион байгуулж ажиллахаар төлөвлөж байна. Хүрсэн түвшин : Орон нутагт оёдлын чиглэлийн хоршоо байгуулагдаж, тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.	100%

62	16. Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг чанаржуулах, бизнес төсөл боловсруулах чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, их дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудтай хамтран техник туслалцааны ажлыг нэвтрүүлэх	Тухайн жилдээ	4	Нэвтрүүлсэн зөвлөх үйлчилгээн ий тоо	-	5	1,0	Бизнесийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр Мерит төсөл, Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран Бэлтгэн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх боломж, Бизнесийн салбарт эмэгтэйчүүдийн манлайлал сэдвээр мэргэжлийн зөвлөх багшийн сургалтанд нийт 75 бизнес эрхлэгчдийг хамруулсан байна. Хүрсэн түвшин : Нийт оролцогчдын 50 хувьд нь хөдөө сумдын бизнес эрхлэгчдийг хамруулсан.	70%
63	17. ТХХЗөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	Тухайн жилдээ	12	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тоо	-	14	-	Төр, хувийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газрын захиалгаар Азийн хөгжлийн банкны санхүүжилт бүхий "Зүүн бүсийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх" төслийн хүрээнд ноос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-г боловсруулж аж ахуй нэгжид 2022 онд хүлээлгэн өгсөн. Тус ТЭЗҮ-н дагуу сард 200 тонн боловсруулах хүчин чадал бүхий ноос боловсруулах үйлдвэрийг 2023 онд Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж буй "Дөрвөн гэгээн эрдэнэ" ХХК хувийн хөрөнгө оруулалтаар ашиглалтанд оруулаад байна. Хүрсэн түвшин : Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд ноос боловсруулах үйлдвэр ашиглалтанд орсон.	70%

64	1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	1. Аялал жуулчлалын бүс нутагт эко ариун цэврийн байгууламж /00/ байгуулах	Тухайн жилдээ	2	Шинээр байгуулах эко ариун цэврийн байгууламж ийн тоо	Орон нутгийн төсөв 85,0	3	45,0	Алтан овооны 110 жилийн ойн хүрээнд Аялал жуулчлалын бүс нутаг болох Алтан овоо, Зэгст нууранд хөрсөнд нэвчдэггүй стандартын шаардлагад нийцсэн Эко нойл 7 ширхэгийг хийж байрлуулсан. Дээрх ажлыг ОНХС-ын хөрөнгөөр 45 сая төгрөгийн санхүүжилт гаргаж гүйцэтгэгчээр Ховдтул ХХК ажилласан.Мөн ойн арга хэмжээний үеэр зөөврийн 00-ийн үйлчилгээг мэргэжлийн байгууллага болох Мөнхийн хүндлэл ХХК- иар 50 ш энгийн 00 ийг 39,996,000 төг, 10 ш люкс 00-ийг 11,341,000 төг гүйцэтгүүлсэн.	100%
65	1. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, ухаалаг системд суурилсан тээвэр, логиستيкийн сүлжээг байгуулна.	1. Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай хүнд даацын авто зам барих ажилд орон нутгаас дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	Тухайн жилдээ	-	Баруун-Урт-Бичигт чиглэлийн 277.3 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар	Төр, хувийн хэвшлийн түншлэл 332700,0	30	-	Бүсийн зөвлөгөөн уулзалт арга хэмжээнүүдийн үеэр аймаг орон нутгийн удирдлагаас тус ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх, ажлыг эхлүүлэх саналыг төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газарт уламжлан ажиллаж байна. Хүрсэн түвшин : -	100%
66		2. Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлж, санал санаачилга гарган хамтран ажиллах	Тухайн жилдээ	-	Хөөт-Бичигт чиглэлийн 234.1 км төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	Төр, хувийн хэвшлийн түншлэл 111960,0	100	-	Шинэ сэргэлтийн бодлого, боомтын сэргэлтийн хүрээнд Засгийн газраас Хөөт-Бичигт чиглэлийн 234 км төмөр замын ажлыг эхлүүлэх шийдвэр гарсан. Энэ төслийн ажлын ТЭЗҮ нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажилд орон нутгаас шаардлагатай мэдээллийг "Монголын Төмөр зам" ТӨХК-д гарган хүргүүлсэн. Хүрсэн түвшин : Судалгаа мэдээлэл, саналыг холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна.	100%

67		3. Бичигт боомт орчмын шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж дэд бүтцийн ажлыг эхлүүлэх	Тухайн жилдээ	-	Ажлын гүйцэтгэл /хувь/	Орон нутгийн төсөв 3600,0	30	291,5	Бичигт боомт орчмын шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн дагуу Ланд овнер ХХКомпанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдснаар бичигт орчмын хот суурин газрын дахин төлөвлөлт, ачаа тээврийн үйлчилгээний авто зогсоол, нурмаг ачаа тээвэрлэх түр байршуулах газар зэрэг ажлууд хийгдэж шинэ дэд бүтэц бүхий суурьшлын бүс үүсэх юм. Тус хэсэгчилсэн төлөвлөгөөг сум аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж инженер, дэд бүтэц бүхий ТЭЗҮ хийгдэж байна Хүрсэн түвшин : 90%	90%
68	1. Барилга хот байгуулалт	1. Үерийн байгууламж барих судалгаа, зураг төслийн ажлыг эхлүүлэх /Баруун-урт/	Тухайн жилдээ	-	Ажлын гүйцэтгэл, хувь	Улсын төсөв 250,0	80	-	Сүхбаатар аймгийн үерийн усны сувгийн байгууламжийн зураг төслийг боловсруулах ажлыг гүйцэтгэгч компаниас үнийн санал авч зураг төслийн ажлыг 2024 оны улсын төсөвт оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Хүрсэн түвшин : -	30%
69		2. Төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон сууцны барилга, хотхон, хороолол барих ажлыг Баруун урт хотын "Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөн"-д нийцүүлэн үе шаттай хэрэгжүүлэх	Тухайн жилдээ	200	Шинээр баригдсан орон сууцны тоо, аялаар	-	460	2300,0	Төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон сууцны барилга, хотхон, хороолол барих ажлыг Баруун урт хотын "Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөн"-д нийцүүлэн үе шаттай хэрэгжүүлэн 960 айлын орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээг Төсөл төсөв ХХКомпани тус онд батлагдсан төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн байна. Мөн шинэ суурьшлын бүс бий болгох зорилгоор Эко 2 төслийг хэрэгжүүлэн 43 айлын амины орон сууцны зориулалттай хорооллыг барих ажлыг гэрээний дагуу Хүрд ХХКомпани гүйцэтгэж байна. Хүрсэн түвшин : Орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ барих ажлын тус онд батлагдсан төсвийн дагуу хийгдсэн байна. Эко 2 хорооллын ажил хийгдэж байна. ажлын явц 30 хувь	100%

[illegible]

72	1. Иргэн төвтэй хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, ногоон технологи бүхий сайн засаглалыг хөгжүүлнэ.	1. erp.e-mongolia.mn цахим системийг аймгийн хэмжээний төрийн байгууллагуудад бүрэн нэвтрүүлж ажиллах	Тухайн жилдээ	114	Цахим системийг нэвтрүүлсэн байгууллагын тоо	АЗДҮАХ 3,0	125	-	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.1 тусгагдсаны дагуу аймгийн хэмжээний төрийн байгууллагуудад удирдлагын нэгдсэн системийг амжилттай нэвтрүүлсэн. Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд 135 байгууллага, 2816 албан хаагч бүртгэлтэйгээр үйл ажиллагаандаа ашиглаж байна.2023 оны байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 01 дүгээр сараас эхлэн төлөвлөгөөт танхим болон цахим сургалтуудыг "Төрийн байгууллагуудад дотоодын үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем" - ийн хэрэглээ, ашиглалтын чиглэлээр зохион байгуулж 13 сум, 7 төрийн байгууллагын нийт 217 албан хаагчдыг хамруулсан. Төрийн байгууллагуудын хооронд цахим хэлбэрээр албан бичиг солилцох чиглэлээр албан бичиг солилцооны дундын системд байгууллага бүртгүүлэх, тус системээс үүсгэсэн токенг байгууллагын erp системд холболт хийлгэх талаар харьяа сумд, төрийн байгууллагуудад албан тоотыг хүргүүлж ажиллалаа. 11 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээнд docx.gov.mn системд нийт 51 байгууллага бүртгүүлж токен үүсгэн төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд 48, eDoc системд 3 байгууллага холболтоо хийж ажилласан. Хавсралт : 1 зураг	100%
----	--	---	---------------	-----	--	------------	-----	---	--	------

73	2. Иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх	Тухайн жилдээ	- -	Тоон гарын үсэг олгосон иргэдийн эзлэх хувь Тоон гарын үсгийн сургалтад хамрагдсан иргэдийн тоо	Орон нутгийн төсөв 2,0	30 400	-	Монгол улсын иргэнд тоон гарын үсэг олгох тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсээр дамжуулан 2023 оны 10 дугаар сард 1407 иргэнд иргэний үнэмлэх дээр суурилсан тоон гарын үсгийг олгон ажилласан. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 16-аас дээш насны 13000 гаруй иргэнд иргэний үнэмлэхний чип-д суурилсан тоон гарын үсгийг олгоод байна. Хэрэгжилтийн хувь 40 гаруй хувьтай. Төрийн байгууллагын албан тушаалтны тоон гарын үсгийг 100 гаруй албан хаагч авч, хэрэглээндээ ашиглаж байна. Хүрсэн түвшин : 13000 иргэн	90%
74	3. Төрийн үйлчилгээний e-mongolia платформд холбогдох, төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	Тухайн жилдээ	2500	Үйлчилгээ авсан иргэдийн тоо:	АЗДҮАХХЗ 2,0	3000	-	И Монгол академи УТУГазрын 01/130 тоот "Хамтран ажиллах тухай" албан бичгийн дагуу Архитектур төлөвлөлтийн даалгавар батлуулах, барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн гэрчилгээ олгох, эмнэлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээнүүдийг operator-e.mongolia.mn цахим систем оруулахтай холбоотой судалгааг гарган Имонгол академид хүргүүлээ. Цахим шилжилтийн ажлын төлөвлөгөөний "Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг цахимжуулах замаар чанар, хүртээмж, ил тод, нээлттэй, шуурхай байдал, иргэдийн оролцоог сайжруулах" зорилтын хүрээнд төрийн үйлчилгээний цахим систем e-mongolia.mn - ийн хэрэглээг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах, үйлчилгээний ашиглалтыг сайжруулах арга хэмжээг тусган өгч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн системд оператораар дамжуулан 50 гаруй төрлийн үйлчилгээг 547 иргэнд үзүүлсэн. 2023 оны 01 дүгээр сараас 11 дүгээр сарын хооронд нийт 4720 иргэнд үйлчилгээг үзүүлээд байна. Хүрсэн түвшин : 4720 иргэн	100%

75	4. Аймгийн нутгийн удирдлагын ордоны засвар	Тухайн жилдээ	-	Ажлын гүйцэтгэл	Орон нутгийн төсөв 300,0	100	-	Энэ ажил тодотголоор хөрөнгө нь хасагдсан. Нийтлэг үйлчилгээний газар шаардлагатай урсгал жижиг засваруудыг хийж гүйцэтгэж байна. Хүрсэн түвшин : -	30%
76	5. Сумдын ЗДТГ-ын газарт автомашины дэмжлэг үзүүлэх	Тухайн жилдээ	-	Хамрагдах сумын тоо	Орон нутгийн төсөв 2250,0	10	2250,0	10 сумын Засаг даргын тамгын газарт автомашин 2.250.0 сая төгрөгөөр худалдан авах тендерийг зарлаж, гүйцэтгэгчээр "Майнт аф"ХХК шалгарч эдгээр автомашиныг захиалагч талд нийлүүлэхэд бэлэн болсон Хүрсэн түвшин : 10 сум	100%

77	6. Хил хамгаалах, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, байгууллагын үйл ажиллагааны материаллаг баазыг бэхжүүлэх	Тухайн жилдээ		0184, 0146 ангиудыг нисдэг тусгай дроноор хангасан тоо Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын гараж бариулах ажлын гүйцэтгэл, хувиар ЦГ-т пургон автомашин ы дэмжлэг	Орон нутгийн төсөв 40,0 Орон нутгийн төсөв 19,8 Орон нутгийн төсөв 60,0	2 100 1	119,8	1. Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн "Эрх шилжүүлж, хөрөнгө гаргах тухай" А/94 дүгээр захирамжийн дагуу 2023 оны аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан нэгдүгээр хавсралт дахь төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх эрхийг холбогдох сумдын Засаг дарга нарт болон холбогдох төсвийн шууд захирагч нарт шилжүүлсэн байдаг. Уг захирамжийн дагуу дараах 3 ажил хийгдэхээр төлөвлөгдөж, үүнээс 2 арга хэмжээ нь бүрэн биелж, үлдсэн 1 нь хөрөнгөө шилжүүлэн аваагүй, эрчимжүүлэх шаардлагатай байгаа болно. 1. Сүхбаатар аймгийн Онгон сумын Хилийн 0184-р ангийг нисгэгчгүй дроноор хангахаар ОНТ-н 25,000,000 төгрөгөөр "Autel Evo 2Pro" маркийн дроныг шийдвэрлэсэн. 2. Сүхбаатар аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ОНТ-н 19,800,000 төгрөгөөр авто тавиулан байгуулсан. 2. Эрдэнэцагаан сумын Хилийн 0146-р ангийг хяналтын камераар хангахаар ОНТ-н 15,000,000 төгрөг төсөвт батлуулсан ба аймгийн Засаг даргын 2023 оны 03 сарын 03-ны өдрийн "Эрх шилжүүлж, хөрөнгө гаргах тухай" А/94 дүгээр захирамжаар төсвийн шууд захирагч нар хэрэгжүүлэх эрхийг олгосон. Бусад байгууллагын хувьд, Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газарт пургон худалдан авахад ОНТ-өөс 60,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн Хүрсэн түвшин : 90%	90%
----	--	---------------	--	--	---	---------------	-------	---	-----

78		7. Аймгийн хэмжээний төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Тухайн жилдээ	70	3-аас доошгүй жил ажилласан албан хаагчийн эзлэх хувь	Орон нутгийн төсөв 450,0	75	450,0	Аймгийн ИТХ-аас баталсан Хүний нөөцийн нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, журмыг боловсруулан батлуулсан. Журмын дагуу АНЭ-ийн сувилагч 2 өрхөд 20,0 сая төгрөгийн орон сууцны урьдчилгааны дэмжлэг, ажлын байран дээрээ мэргэжил олгох сургалтад хамрагдсан 24 сувилагчийн сургалтын зардал 37,6 сая төгрөг, ерөнхий боловсролын сургуулийн 8 багшид орон сууцны дэмжлэг тус бүр 20,0 сая төгрөг, эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа төгсөх ангийн 10 оюутанд тус бүр 4,0 сая төгрөгийн дэмжлэгийг олгоод байна. Журмын дагуу нарийвчилсан удирдамж гарган нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг хууль журмын дагуу дэмжлэгийг олгосон. Хүрсэн түвшин : 100	100%
79	1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, илрүүлэлтийг улсын дунджаас дээш түвшинд хүргэнэ.	1. Баруун урт хотын шаардлагатай цэгүүдэд камер нэмж суурилуулах	Тухайн жилдээ	-	Шинээр суурилуулсан камерын тоо	Орон нутгийн төсөв 150,0	5	475,0	Аймгийн хэмжээнд “НОГООН БҮС” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн төсвөөс 350.0 сая, Баруун-Урт сумын төсвөөс 125.0 сая, нийт 475.0 сая төгрөгийг Баруун-Урт сумын төвийг камержуулах, хяналтын нэгдсэн төвийг байгуулах ажилд шийдвэрлүүлсэн. Эхний удаа гэмт хэрэг, зөрчлийн дуудлага ихээр бүртгэгддэг Баруун-Урт сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрийг камержуулах, хяналтын нэгдсэн төвд холбох ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд Баруун-Урт сумаас зарлагдсан тендэрт “Арш технологи” ХХК гүйцэтгэгчээр шалгарч, тус багийн нутаг дэвсгэрт дугаар танигч болон чиглэлийн 24 ширхэг камерыг суурилуулж, цагдаагийн газарт “Хяналтын нэгдсэн төв”-ийг шинээр байгуулахаар ажиллаж байна Хүрсэн түвшин : 24	90%

80	2. Оногдуулан данслагдсан бэлтгэл үүрэгтнүүдийн сургалтыг зохион байгуулах	Тухайн жилдээ	-	-	Улсын төсөв 2,5	-	-	Эрдэнэцагаан суманд зохион байгуулсан Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн дадлага сургуульд оролцсон нэг болон хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүдэд онолын болон дадлагын хичээлийг явуулсан. Хүрсэн түвшин : тийм	100%
81	3. 338-р ангийн буудлагын бателон	Тухайн жилдээ	Газар шийдвэрлэгдсэн	Ажлын гүйцэтгэл, хувиар	Орон нутгийн төсөв 85,0	30	80,0	Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн сургалтын төвийн /полигон/ тусгай хэрэгцээний эзэмшлийн газрыг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэн сургалтын төвийн гүйцэтгэлийн ажилд зарцуулах 80.000.000 төгрөгийг аймгийг ИТХ-аар батлуулан аймгийн төсөвт дагуу санхүүжилтийг олгож гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байгаа Хүрсэн түвшин : 90	90%

[illegible]

84	1. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулна.	1. Ойгоор бүрхэгдсэн талбай хэмжээг нэмэгдүүлэх	Тухайн жилдээ	25 га 5 га/35%	Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ Арчилгаа хийсэн талбайн хэмжээ, модны ургалтын хувь	БХНСАХЗ, төсөл хөтөлбөр 168,7 БХНСАХЗ, 21,7	30 га 5 га/70%	271,7	Баруун Урт суманд Улаанбаатар гарах зам дагуу 5 га-д 56,2 сая төгрөгөөр ойн зурвас байгуулах ажлыг Ойжуулалт Хайлааст ХХК гүйцэтгэж 4000 мод 80%-ийн ургалттай байна. - Баруун-Урт сумын Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-т модны нүх ухагч тракторыг 100.0 сая төгрөгөөр нийлүүлсэн. - Баруун-Урт суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5 га-д 46.0 сая төгрөгөөр Ойн зурвас байгуулах ажлыг Сүхбаатар Ойжуулалт сум дундын ойн анги хэрэгжүүлж байна. 2023 оны 10 сард нөхөн тарилт хийсэн, хавар ургалтын хувийг тогтооно. - Дарьганга суманд 20 га газарт ойн зурвас байгуулах ажлыг Сүхбаатар ойжуулалт СДОАнги 57.0 сая төгрөгөөр гүйцэтгэж байна, ургалт 5%-тай. - АДАПТ төслийн хүрээнд Дарьганга сум-30 га, Түмэнцогт сум -20 га-д татмын ойжуулалт, мөн Дарьганга сум-10 га, Түмэнцогт сум -15 га-д тармаг ойн цэвэрлэгээ хийх ажлын тендер зарлагдаж Дарьганга сумын 30 га-д Гранд форест ХХК шалгарч гэрээ байгуулах шатанд явж байна. - Баруун-Урт суманд Наадан явах замд улсын төсвийн 112.5 төгрөгийн хөрөнгөөр 10 га газар ойн зурвас байгуулах ажлыг хашаа хамгаалалтын хамт 2023 оны 10 сард хийгээд байна, ургалтын хувийг 2024 оны хавар тогтооно. -Сүхбаатар аймагт Агро ойжуулалт хийх саналыг Гео Экологийн хүрээлэнд тавьсан ба Баруун-Урт суманд 10 га газарт ТЭЗҮ хийх судалгааны ажлыг эхлүүлээд байна. 2023.09.17-нд Гео Экологийн хүрээлэнгийн судалгааны баг	90%
----	---	---	---------------	----------------------	--	---	-------------------	-------	---	-----

85	2. Эвдэрч, эзэнгүй орхигдсон газарт нөхөн сэргээлт хийх	Тухайн жилдээ	100	Нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ, га Ургалтын хувь	БХНСАХЗ 60,0	4 га 80	-	Орон нутгийн төсвийн 60 сая төгрөгөөр эвдэрч эзэнгүй орхигдсон 4 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр төлвөлсөн боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар зураг төсөвгүй ажлуудыг тендер зарлаж болохгүй талаар мэдэгдсэн тул уг ажлыг хэрхэн хийх талаар 145 тоот албан бичгээр зөвлөж чиглэлийг БОАЖЯ-наас хүсээд байна. Дэд ажлын хэсгийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж 5 аж ахуйн нэгжийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүйцүүлэн хагаалах арга хэмжээнд нь эвдэрч эзэнгүй орхигдсон талбайгаас техникийн нөхөн сэргээлт хийлгэхээр тусгаад байна. Авто замын ажил хийж байгаа Монгол зам групп болон Их богд зам, Ханан салхит ХХК-уудад урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт шалгалтанд хамрагдах тухай 135, 136 тоот албан бичиг, мөн карьерын нөхөн сэргээлтийг хугцаанд нь хийж хүлээлгэн өгөх талаар 164 дугаартай албан бичиг хүргүүлээд байна. Аж ахуй нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд тусгагдсан эвдэрч эзэнгүй орхигдсон талбайд техникийн нөхөн сэргээлтийг 2022 оны биелэлтээ Нагааранз ХХК 1 га, Дорнын чулуулаг ХХК 1,72 га Монголжүюаньли ХХК 1 га, 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс Цайртминерал ХХК 1 га, Монголжүюаньли ХХК 1 га, Хунт өгөөж ХХК 1 га, Говьмастер ХХК 1 га талбайд тус тус хийгээд байгаа талаар тайлан мэдээ ирүүлээд байна. Уг ажлыг ажлын хэсгээр	90%
----	---	---------------	-----	--	-----------------	------------	---	--	-----

86	3. Сум дундын болон сумын ойн ангийн техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулах	Тухайн жилдээ	0	Модны нүх ухагч тракторын тоо	Орон нутгийн төсөв 100,0	1	100,0	Баруун-Урт сумын Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-т модны нүх ухагч тракторыг 100.0 сая төгрөгөөр нийлүүлсэн. Сүхбаатар-Ойжуулалт" Сум дундын ойн ангид БОАЖЯ-наас 8.0 сая төгрөгний төсөвт өртөг бүхий Хүлэмж болон бороожуулагчийн дэмжлэг үзүүлсэн. Сум дундын ойн ангийн 4 ажилтан 2 удаагийн сургалтанд хамрагдсан. Үүнд: 1. БОАЖЯ-наас зохион байгуулсан "Мод тарих 1000 сургагч багш " бэлтгэх сургалтанд 3 ажилтан хамрагдаж сертификат олгогдсон. 2.Цэцэрлэгч-сургагч багш" бэлтгэх сургалтанд 4 хүн хамрагдаж сертификат олгогдсон. Хүрсэн түвшин : тийм	90%
87	4. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлэх, техник багаж хэрэгслээр хангах	Тухайн жилдээ	3000 4	Мэдээ хүлээн авагч хүний тоо Үлээгч аппарат авах тоо	БХНСАХЗ 10,0	4000 10		-Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажилд Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 10.0 сая төгрөг төлөвлөсөн. Үүний дагуу аймгийн УЦУОШТөв, Юнитель салбартай гурвалсан гэрээг хийж түймрийн хуурайшилтын үе 3-р сарын 20-ноос 6-р сарын 20-ны хүртэл 3 сарын хугацаанд хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна. тайлангийн хугацаанд эрсдэл бүхий сумдын малчин өрх болон иргэдэд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг мэдээллээр хангах ажлын хүрээнд Баруун-Урт , Түмэнцогт, Мөнххаан, Сүхбаатар, Асгат, Дарьганга, Эрдэнэцагаан сумдын хөдөөгийн багийн нийт 3214 айл өрхөд МАСС МЕССЭЖ анхааруулга мэдээллийг хүргэж ажилласан. Мэссэж мэдээг 3 сарын турш 9 удаа илгээж мэдээллийг хүргэж 578,500 мянган төгрөг зарцуулсан. Шатахууны зардалд 1500.0 төгрөг зарцуулсан. - Эрдэнэцагаан сум ОНХС-аас 5.0 сая төгрөгөөр 10 ш түймэр унтраагч багажтай болсон.	70%

5. Нэн ховор, ховор, ашиглалтад өртөмтгий ургамлыг тарималжуулах, хамгаалах	Тухайн жилдээ	-	тарималжуулсан ургамалын талбайн хэмжээ	БХНСАХЗ 15,0	0,5га	Сүхбаатар аймгийн хэмжээнд ургамалжилтын судалгааг 2020 онд мэргэжлийн байгууллагаар хийлгэж зарим нэг зүйлийн эмийн Нэн ховор, ховор, ашиглалтад өртөмтгий ургамлыг тарималжуулах, хамгаалах зорилгоор судалгаанд үндэслэн Нарийн цахилдаг /Iris tenuifolia Pall/ ургамалыг сонгон авч 2023 онд хамгаалалтын хашааг татах ажлыг хийгээд байна. Дээрх ажлыг Асгат, Халзан сумын зааг нутагт 0,5 га газрыг сонгоод 300 м хамгаалалтын хашааг нь бүрэн хийж байрлуулахад бэлэн болгосон. Цаашид ургамлын үрээ түүх, үрээ боловсруулах, тарих ажлуудыг шат дараатай хийхээр төлөвлөөд байна. Хүрсэн түвшин : 0,5 га	90%
---	---------------	---	---	-----------------	-------	--	-----

89	6. Дарьганга, Түмэнцогт сумдад Монгол тарвага сэргээн нутагшуулах	Тухайн жилдээ	200	нутагшуулс ан тарваганы тоо	БХНСАХЗ 16,5	260	-	Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт биологийн төрөл зүйлийг хамгаалах төслийн санхүүжилтээр Түмэнцогт, Мөнххаан суманд 100 толгой, БОАЖГазар БХНСАХэмжээний зардлаар Дарьганга, Түмэнцогт суманд 60 толгой, Орон нутгийн төсвөөр Уулбаян суманд 50 толгой, Халзан суманд 30 толгой, аймгийн хэмжээнд нийт 240 толгой Монгол тарвага сэргээн нутагшууллаа. Баяндэлгэр сумын Дөхмийн Баян-Овоо, Улаан хад, Дарьганга сумын Баруун Нартын уул, Түвшинширээ сумын Малгарын уул зэрэг газарт байршидаг Аргаль хонинд өвөлжилт хүндэрч идэш тэжээлийн хомсдолд орсон тул дээрх байршлуудад нийт 500 боодол ногоон тэжээлийг байгаль хамгаалагчдынхаа тусламжтайгаар тавьж өглөө. Мөн Эрдэнэцагаан сумын Лхачинвандадын байгалийн нөөц газарт байршдаг Халиун буганд нутгийн иргэдтэй хамтран 5 тн хужир шүү тавьж өгч ажиллалаа. Ингэснээр зэрлэг амьтны хорогдол тухайн газруудад гараагүй болно. Хавсралт : 3 зураг Хүрсэн түвшин : 240 тарвага	90%
----	--	------------------	-----	--------------------------------------	-----------------	-----	---	--	-----

90	7. Төвлөрсөн ундны усны хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх	Тухайн жилдээ	3	Тэмдэгжүүлэлт хийсэн сумын тоо	БХНСАХЗ 20,0	3	19,8	БОАЖСайд аймгийн Засаг дартай байгуулсан гэрээний 27.1, Усны тухай хуулийн 22.10.2, БОАЖСайд, БХБСайдын хамтарсан А-230/127 тушаалын 3.1 дэх заалт, аймгийн АЗДҮАХ-ийн 5.1.4, 2024 оны аймгийн хөгжлийн төлөвлөгөөний 3.1.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн хэмжээнд “Төвлөрсөн ундны усны хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх” ажлыг БХНСАХЗардалаас 19.827.800 /арван есөн сая найман зуун хорин долоон мянга найман зуу/ төгрөгөөр Асгат, Сүхбаатар, Түвшинширээ, Дарьганга сумдын 16 эх үүсвэрт /100х80/ хэмжээнтэй 16 самбар, /50х50/ хэмжээтэй 16 самбарыг байршуулсан. Хавсралт : 3 зураг Хүрсэн түвшин : 4 сумын 16 эх үүсвэрт 16 самбар байрлуулав.	100%
----	--	---------------	---	--------------------------------	--------------	---	------	---	------

91	8. Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах.	Тухайн жилдээ	3	Шинээр хашиж хамгаалсан булгийн тоо	БХНСАХЗ 33,7	6	-	БОАЖСайд аймгийн Засаг дартай байгуулсан гэрээний 28.2, ЗДҮАХ-ийн 5.1.4.5 заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд тендерт Тогоон төмөр ХХК шалгарч булгийн эхийг хашиж хамгаалсан ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Уулбаян сум – Хөөвөр Эрдэнэцагаан сум – Наран Халзан сум – Ар булаг Наран сум – Зүүн булаг /Тосонгийн гол баг/ Баяндэлгэр – Зүүн булаг Түвшинширээ сум – Сэвхүүл булгийн эхийг АДАПТ төслөөс 70 хувь, Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалаас 30 хувийн санхүүжилтээр Мөнххаан сум -Батбулаг - 5.0 сая.төг /ОНХС/ Түмэнцогт сум - Сэмүүний булаг - 2.8 сая.төг /ОНХС/ Түмэнцогт сум - Баян-Овоо булаг - 2.8 сая.төг /ОНХС/ Эрдэнэцагаан сум - Аман - Ус / Эрээнтолгой ХХК/ Эрдэнэцагаан сум - Бага бүлэг /Эрээн толгой ХХК/-ийн санхүүжилтээр тус тус хашиж хамгаалсан. Булгийн эхийг хашиж хамгаалснаар гадаргын болон газрын доорхи усны нөөц бохирдож, хомсдохоос хамгаалагдсан. Хавсралт : 3 зураг Хүрсэн түвшин : 11,0	100%
92	9. Эрүүл ахуйн ахуйн шаардлага хангасан хогийн цэгийн тоог нэмэгдүүлэх	Тухайн жилдээ	4 11га	Дэмжлэг үзүүлсэн сумын тоо, Хуучин хогийн цэгийг нөхөн сэргээсэн талбай	БХНСАХЗ 10,0 Баруун урт сум төсөв 40,0	6 20га	20,0	2023 онд Онгон, Асгат, Наран Дарьганга сумд Нэгдсэн хогийн цэгийг хумих, цэгцлэх, булшлах ажлыг Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр зохион байгуулж ажиллаж байна. Онгон сум 20,0 сая төгрөгөөр 8 га талбайг 2 га-аар, Асгат сум 10 сая төгрөгөөр 6 га талбайг 2 га-аар, Наран сум 2,0 сая төгрөгөөр 3 га талбайг 1 га-аар, Дарьганга сум 5 сая төгрөгөөр 5 га талбайг 2 га-аар тус тус багасгаад байна Хүрсэн түвшин : 4 сум, 7 га	100%

93	10. Аймгийн хэмжээнд ангилан ялгадаг хогийн сав хийж байршуулах	Тухайн жилдээ	200ш -	Ангилан ялгадаг хогийн сав Хуванцар хаягдлын сав	Баруун урт сум төсөв 100,0	20ш 30ш	-	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хогийн сав Баруун-урт сум шинээр баригдсан орон сууц 3 ш, Асгат сум 3 ш, Мөнххаан сум 5 ш, Уулбаян, Дарьганга, Наран, Баяндэлгэр, Түвшинширээ, Түмэнцогт сумд тус бүр 1 ш нийт 17 ш хогийн сав байршуулсан Хавсралт : 2 зураг Хүрсэн түвшин : 17 ш хогийн сав	100%
94	11. Иргэдэд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг суулгах нөлөөллийн ажил зохион байгуулж,	Тухайн жилдээ	25 15	Зохион байгуулсан сургалтын тоо Байршуулсан мэдээллийн самбарын тоо	БХНСАХЗ 2,0 БХНСАХЗ 15,0	30 14	12,5	Хог хаягдлын менежментийг сайжруулах, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, иргэдийг хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах талаар нийт 18 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 20 ААНБ-ын 450 хүн, 17 ЕБС-ын 3200 хүүхдэд зохион байгуулсан. Мөн 13 суманд сургалтын материал болгож БХНСАХЗардлаас 2.0 сая төгрөгөөр сургалтын хэрэглэгдэхүүн тараах материал 8000 ш-ийг тараасан. Орон нутгийн төв -д -5 удаа, байгууллагын веб сайт, FB-ээр 6 төрлийн 65 мэдээллийг бэлтгэн байршуулахад 12784 хүний хандалт авсан байна. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах талаар иргэдэд мэдээллийн самбар БХНСАХЗардлаас 12,563,000 төгрөгийн санхүүжилтээр 13 суманд 15 ш самбарыг байршуулан ажиллалаа. Мөн зуны урин дулаан цаг болж дотоодын жуулчдын урсгал нэмэгдэж байгааг тохиолдуулан "ИРЛЭЭ, ЯВЛАА, ЦЭВЭР" аяныг эхлүүлээд байна. Аянтай холбоотойгоор 8 төрлийн постер гаргаж цахим орчинд байрлуулж, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хийж байна. Хандалт 80 шэйр, 104 лайк, 12 сэтгэгдэлтэй байна. Хавсралт : 3 зураг Хүрсэн түвшин : 15 ш самбар,	100%

95		12. Эзэнгүй хог хаягдлыг 40 хувиар бууруулах	Тухайн жилдээ	430 тн 0 4	Цэвэрлэсэн эзэнгүй хог хаягдлын хэмжээ тн 15 тн ангилсан хог шахаж тээвэрлэх машин худаладан авсан эсэх Дахивар хог худалдан авах нөөц бүрдүүлэлт, тн	БХНСАХЗ 9,0 Баруун урт Сумын төсөв 100,0 Баруун урт Сумын төсөв 20,0	500 тн 1 50	109,2	2023 оны 1-10 сард Иргэдийн хог хаягдлын боловсролыг дээшлүүлэх хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах чиглэлээр “Цэвэр орчин Цэнгэг агаар” 15 сургалтыг зохион байгуулсан. Нийт насанд хүрсэн 517 иргэн, ЕБ сургуулийн 984 сурагчид сургалт хийсэн. БОАЖС-ын 2022 оны А/518 дугаар тушаал, БОАЖС-ын А-02 албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны 02 сарын 27-ны өдрийн А/48 дугаар захирамжын дагуу эзэнгүй хог хаягдал малын сэг зэм устгал аймгийн хэмжээнд сум бүр 2 удаа хийсэн. Үүнд: Адуу-10318 Үхэр -8878, Тэмээ-13,Хонь-28084, Ямаа 45976, Зээрийн сэг зэм 22, нохой 275 ш Нийт 93269 ш-ийг устгаж, 109.179.000 төгрөгийн зардал гаргаж 460000 м2 газрыг халдваргүйжүүлэлт хийж ажилласан байна. Хүрсэн түвшин : 460000 м2	100%
6. БҮС,ОРОН НУТГИЙН БОДЛОГО										
96	1. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хот болгон хөгжүүлнэ.	1. Баруун урт сумын 9-р багийг цэгцлэх	Тухайн жилдээ	-	Эзлэх талбай, га	Орон нутгийн төсөв 10,0	20-30 га	100,0	9- дүгээр багийн цэгцлэх ажлын хүрээнд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна Хүрсэн түвшин : 50%	50%
97		2. 960 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний эхний ээлжийг дуусгаж газрын дуудлага худалдаа зарлаж орон сууцны барилга эхлүүлэх	Тухайн жилдээ	-	960 айлын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Улсын төсөв 3000,0	10	2300,0	960 айлын орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээ шинээр барих ажлын тендерт Төсөл төсөв ХХКомпани гүйцэтгэгчээр шалгарч батлагдсан төсвийн дагуу ажлаа хийж гүйцэтгэсэн байна. Хавсралт : 2 зураг Хүрсэн түвшин : 90%	90%

98	3. Эко-2 хотхон байгуулах	Тухайн жилдээ	-	Суурь дэд бүтэц ажлын гүйцэтгэл /хувь/	Орон нутгийн төсөв 2000,0	30	2000,0	Шинэ сууршлын бүс бий болгох иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн шугам сүлжээ бүхий 43-н айлын амины орон сууц барих газрыг төлөвлөн хийж гүйцэтгэж байна. Тус ажлын тендерийг зарлан Хүрд ХХКомпани гүйцэтгэгчээр шалгарч хийж гүйцэтгэж байна. Хүрсэн түвшин : 70%	70%
99	4. Уртын голын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг хийх	Тухайн жилдээ	40га	Нийт эзлэх талбай, га	Улсын төсөв 2500,0	166 га	9,3	Уртын голын цэцэрлэгт хүрээлэн барих тохижилтын ажлыг Их модун ХХКомпани хийж гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд задгай театр, явган зам, авто зам, дугуйн зам, далан гүүрний тохижилтын ажил, спорт амралт, зугаалгын талбай, ногоон байгууламж, хашаа хайлс, үйлчилгээний нэгдсэн төвүүд барих ажлууд хийгдэж байна. Хавсралт : 3 зураг Хүрсэн түвшин : 70%	70%
100	5. Дашбалбар агсны нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулах	Тухайн жилдээ	-	Нийт эзлэх га	Орон нутгийн төсөв	""	2200,0	Зохиолч, яруу найрагчдын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн барих /Талын наран цэцэрлэгт хүрээлэн/ ажлын зураг төсвийг Зууны гүүр ХХКомпани гүйцэтгэж байгаа бөгөөд одоогоор тус зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт тохижилтын ажил болох гэрэлтүүлэг, ногоон байгууламж, хайш хашаа, хүндэтгэлийн хаалга, хөшөө дурсгал байршуулах суурь, явган зам талбайн ажил, усалгааны систем бүхий зүлэгжүүлэлт, үйлчилгээний ажлуудыг хийж гүйцэтгэн зураг төсөв магадлалаар баталгаажин тендер зарлахаар бэлтгэл ажилыг ханган ажиллаж байна. Хүрсэн түвшин : -	30%
101	6. Хуучин наадмын талбайн тохижилт ногоон байгууламж	Тухайн жилдээ	-	Нийт эзлэх га	Орон нутгийн төсөв 1800,0	-		Зураг төсөв хийгдэж байна.	50%

102		7. Жил бүр аймгийн төвийн хатуу хучилттай авто замуудад их засвар, нөхөөс тавих ажлыг хийж гүйцэтгэх	Тухайн жилдээ	1200	Хэсэгчилж засварлах замын талбай, м2	Замын сан 300,0	1000	299.8	Аймгийн төвийн замын засвар, арчлалтын ажил гүйцэтгэх СБАОНӨГ/202301067 дугаарт гэрээт ажлын гүйцэтгэгчээр "Монгол зам групп" ХХК шалгаран гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Нөхөөс хийх ажлыг гүйцэтгэсэн, Авто замын хагарлыг битумээр нөхөх, хэсэгчилсэн авто замын их засвар, явган замын ажил хийгдээгүй байна. Ажил гүйцэтгэх гэрээний хугацааг 2024 оны 07 дугаар сарын 01 хүртэл сунгасан. Хүрсэн түвшин : Нийт 47,23 м3 асфальтбетон болон цементбетон засвар нөхөөсний ажил хийгдэж дууссан.	70%
103		8. Эко хорооллын авто замын ажил /Баруун-урт сум/	Тухайн жилдээ	-	Авто замын урт	Замын сан 500,0	-	499.3	ус ажлын гүйцэтгэгч "Монгол зам групп" ХХК-тай СБАОНӨГ/202303092 дугаарт гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн 560 м авто замын далан, суурь, явган замын ажил хийгдсэн. Асфальтбетон хучилт, 11 гэрэлтүүлгийн ажил хийгдээгүй гэрээг сунган 2024 онд ашиглалтад оруулна. Хүрсэн түвшин : 70%	70%
104	1. Сумын хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	1. 3Г-ын 161-р тогтоолын дагуу Мөнххаан, сумын инженерийн шугам сүлжээний ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах	Тухайн жилдээ	-	Ажлын гүйцэтгэл, хувиар	Орон нутгийн төсөв 170,0	50	154,0	Засгийн газрын "СУМЫН ХӨГЖИЛ: ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ХАНГАМЖ" ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ" 2021 оны 161-р тогтоолоор эхний ээлжийн тухайн төсөлд хамрагдахаар болсон Сүхбаатар аймгийн 4 сумын нэг болох Мөнххаан сумын инженерийн шугам сүлжээний зураг төслийг гүйцэтгүүлэхээр орон нутгийн төсөвт 170,0 сая төгрөг батлагдан тендер шалгаруулалтаар 154,0 сая төгрөгийн үнийн санал "Гидродизайн инноваци" ХХК шалгаран зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэж байна. Ажлын явц, гүйцэтгэл 90%-тай байгаа бөгөөд төлөвлөгдсөн барилга, шугам сүлжээний газар нь сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусаагүй улмаас төслийг магадлалаар баталгаажуулах боломжгүй түр зогсонги байдалтай байна. Хүрсэн түвшин : 90,0	90%

105	2. Сумдыг төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны системд холбох ажлыг ТХХТ-ээр хэрэгжүүлэх боломжийг судлах /Уулбаян, Түвшинширээ сум/	Тухайн жилдээ	-	Ажлын явц	Хувийн ХО	50	12000	2022 онд "Эм Эс Ки энд Ти У" ХХК-аас ирсэн 22/024 тоот албан хүсэлт, "Сэтгэшгүй нэмэх" ХХК-аас ирсэн 22/036 тоот албан хүсэлт, сумдын Засаг дарга нараас ирүүлсэн албан хүсэлтүүдэд үндэслэн дээрх төслийг хэрэгжүүлэх БХБЯ болон ЭЗХЯ- уудаас санал 1/199, 03/781 тоот саналуудыг тус тус авч Аймгийн Засаг даргын захирамжаар 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Ажлын хэсэг байгуулагдан холбогдох арга хэмжээнүүдийг авч, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн "Концессийн гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай" 02 дугаар тогтоолоор Түвшинширээ суманд "Сэтгэшгүй нэмэх" ХХК, 03 дугаар тогтоолоор Уулбаян суманд "Эм Эс Ки энд Ти У" ХХК-уудтай Төвлөрсөн дулаан, цэвэр ус хангамж, ариутга татуургын систем барьж байгуулах ажлыг концессын "Барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн. 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдөр тус компаниудтай КГ/01, КГ/02 дугаар бүхий гэрээг байгуулан барилга угсралтын ажил 9 дүгээр сараас эхлэсэн бөгөөд хүйтний улирал эхлэсэнтэй холбоотойгоор түр зогсоод байна. Хүрсэн түвшин : 90%	90%
-----	---	---------------	---	-----------	-----------	----	-------	---	-----

[illegible]